

БАЯНХОНГОР АЙМГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 30

Номгон

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хүрэх түвшин, үр дүн	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
НЭГ.. КОВИД 19 ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО					
1	2	3	4	5	6
1	1.1. Ковид-19 халдварт	1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт корона вирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх	“Ковид-19” цар тахлын эрсдэлийг 50-аас дээш хувь бууруулсан байна.	“Ковид-19” вирусийн халдварын эрсдэлийн салбар дундын үнэлгээг 2021 онд аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран 2 удаа хийж, өндөр эрсдэлтэй гэж үнэлсэн. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг шуурхай төлөвлөн, бэлэн байдлыг хангаж ажилласнаар эрсдэлийн түвшинг 60 хувиар бууруулсан. 2022 оны байдлаар Ковид-19 цар тахлын халдварын тархалт буурч, ногоон түвшинд байгаатай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийгдэх шаардлагагүй байна.	100%
2	цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээ	1.1.2. Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулах	Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр ард иргэдэдэд 20000 удаагийн давтамжтайгаар хүргэнэ.	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн төвөөс бэлтгэн гаргасан Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх 8 төрлийн видео, 19 төрлийн инфографик мэдээлэл, “Их эмч зөвлөж байна” нэвтрүүлгийн 6 дугаар, 2 төрлийн видео шторк бэлтгэн “Баянхонгор телевиз”, “Номгон телевиз”, “Дурсамж лед дэлгэц”-ээр 20000 удаагийн давтамжаар нэвтрүүлж, ЭМГ, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн 24 фэйсбүүк бүлгэм, зарын 20 бүлгэмд байршуулан 20800 удаагийн хандалт авсан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд мэдээлэл сургалт сурталчилгааны төлөвлөгөөний дагуу иргэд үйлчлүүлэгчид эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. “Ковид-19” халдвараас урьдчилан сэргийлэх болон нэмэлт дархлаажуулалтын талаарх мэдээлэл сурталчилгааг орон нутгийн зарын самбарт 3 сарын хугацаанд байршуулан, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 69 удаагийн арга хэмжээгээр 10185 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан.	100%
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
		2.1.1. “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих”	Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүүг 0.2	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр 4 жилээр боловсруулан, аймгийн Засаг даргын 2022 оны А/703 дугаар захирамжаар батлуулж	
1	2	3	4	5	6

3	2.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл	арга хэмжээг хэрэгжүүлэх	хувиар багасгана. Эрэгтэйчүүдийн кабинет байгуулж, төрөлжсөн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	, хэрэгжилт 80 хувьтай байна. Төлөвлөгөөний хүрээнд эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, төрийн байгууллагууд болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 282 эрэгтэй багш ажилчид хамрагдсан. Оролцогчдын сургалтын өмнөх мэдлэг 20 хувь, дараах мэдлэг 70 хувь болж, хорт зуршлаас татгалзах, хавдраас сэргийлэх, зөв хооллох талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн. Аймгийн хүн амын дундаж наслалт 71.28 байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.17, эмэгтэйчүүдийнх 73.21 байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээс 5.04-өөр бага байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 2022 онд 9678 эрэгтэйчүүд хамрагдаж эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр хангаж, тусламж үйлчилгээ үзүүлсэн. ЭМС-ын 2022 оны А/449 дүгээр тушаалын дагуу эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетыг байгуулж, 20 хүнд урологийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж, орны хүлээгдлийг бууруулсан. Энэ чиглэлийн хүний нөөцийг бүрдүүлж урологийн мэргэжлээр 1 эмчийг бэлтгэн, мэс заслын мэргэжлээр 1 эмчийг сургаж байна. 2023 оноос эрэгтэйчүүдийн төрөлжсөн тусламж үйлчилгээний кабинетыг өргөжүүлэн ажиллана.	90%
5		2.1.3. "Халдварын эрсдэлгүй ирээдүй" зорилтот төсөл хэрэгжүүлэх	Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг 5-10 хувиар бууруулна.	"Эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулах тухай" Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/18 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд Бэлгийн замаар дамжих халдварын чиглэлээр үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамрагдсан 5528 тохиолдлоос 653 өвчлөлийг шинээр илрүүлж, хавьтлын хамт 883 иргэнийг эмчилгээнд 100 хувь хамруулан зөвлөгөө өгч ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/30 дугаар тушаалын дагуу эрсдэлт бүлгийн хүн амаас эрсдэл өндөртэй иргэдийн судалгааг гарган, нийтдээ анхан шатны нэгжүүдээс 5600 иргэн БЗДХ-ын үзлэгт хамруулахаас 98.7 хувь хамруулсан. 2022 онд тэмбүүгийн өвчлөл 178 буюу 10 000 хүн амд 20.0 тохиолдол байгаа нь өмнөх оноос 5.6-ээр өндөр, заг хүйтний өвчлөл 245 буюу 10 000 хүн амд 27.5 тохиолдол байгаа нь өмнөх оноос 7.1-оор нэмэгдсэн байна. Эдгээр 2 өвчлөл урьд оны мөн үеэс өссөн нь урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн хамрагдалттай шууд холбоотой . Трихоминиазын өвчлөл 371 буюу 10 000 хүн амд 41.7 тохиолдол	100%
1	2	3	4	5	6

				байгаа нь өмнөх оноос 14.2-аар буурсан. Өмнөх онд нийт халдварт өвчин 18558 байсан бол энэ онд 8198 байгаа бөгөөд өмнөх онд корона вирусийн халдвар дийлэнх хувийг эзэлж байсан. 2021 оны мөн үед БЗДХ-ын тохиолдлын тоо 845 байсан бол 2022 онд 794 болж, 51 тохиолдлоор буурсан. Сүүлийн 2 жилд төрөлхийн тэмбүү өвчин бүртгэгдээгүй. Нийт халдварт өвчний 9.6 хувийг БЗДХ эзэлж өмнөх онуудаас буурсан эерэг үзүүлэлттэй байна.	
6		2.1.4. Сурагчдын шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн шүдний 6 эмнэлгийг түшиглэн, аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдыг үзлэг оношилгоонд үе шаттай хамруулж, илэрсэн өвчлөлийг 100 хувь эрүүлжүүлнэ.	“Хонгор дент” шүдний эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм сургууль, Баян-Ойт, Соого сейкео сургуулиудын 12 насны 1200 сурагчийг шүдний үзлэг, оношилгоонд 100 хувь хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Тус сургуулийн сурагчдад “Шүдний эрүүл ахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, хүүхэд багачуудад мэдлэг олгосон. Эрүүл мэндийн газрын 2018 оны судалгаагаар сурагчдын дундах шүдний цоорлын тархалт аймгийн хэмжээнд 86 хувьтай байсныг тус газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн “Эрүүл мэндийн сургалт, судалгаа шинжилгээний инновацын алба”-наас хэрэгжүүлсэн Шүдний өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох судалгаатай харьцуулан гаргаж, 600 гаруй сурагч хамрагдсан. Аймгийн Өсвөр үеийн кабинет Политехникийн коллежийн 450 сурагчдад амны хөндийн үзлэг хийж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэг шинжилгээний хүрээнд эрүүл мэндийн анхан шатны 24 нэгжээр дамжуулан 7740 сурагчдад шүдний үзлэгийг хийж, зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2022 онд давхардсан тоогоор 11712 хүүхэд, өсвөр үеийнхэнд амны хөндийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээ оношилгоог зохион байгуулан, сургалт мэдээллийг хүргэн ажилласан. Нийт үзлэгт хамрагдсан хүүхдийн 75 хувь нь шүдний цооролт, шүдний гаж хөгжил, шүд чулуужих буйлны үрэвсэлт өвчлөл илэрч байна. Эдгээрээс үзвэл 1 хүүхдэд дунджаар 2-3 шүдний өвчлөл илэрч байгааг 2018 оны судалгаатай харьцуулбал 11 хувиар буурч байгаа хэдий ч нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түлхүү үзүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.	100%
		2.1.5. Эрүүл мэндийн салбарын хүний	Нийгмийн эрүүл мэнд, тархвар судлаач, эрүүл	Эрүүл мэндийн салбарын 120 нэгж байгууллагад нийт 1209 ажиллагсад ажиллаж байна. Үүнээс их эмч 194 буюу 16 хувь	
1	2	3	4	5	6

7		нөөцийн хөгжлийг хангаж, нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг бэлтгэх	мэндийн удирдлагын чиглэлээр 4 мэргэжилтнийг мэргэшүүлнэ.	сувилагч, тусгай мэргэжилтэн 536 буюу 44.5 хувийг эзэлж байна. Одоогоор шүдний эмч, тархвар судлаач, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, ахмадын эмч, багийн эмч дутагдалтай байна. Аймгийн Засаг даргын 2022 оны А/336 дугаар захирамжаар 2022 оны Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг зарцуулан, нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн удирдлагын магистр, сувилахуй зэрэг 5 чиглэлээр 12 эмч, сувилагчийг сургаж байна. 2022 онд давхардсан тоогоор эрүүл мэндийн байгууллагуудын 1700 гаруй эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн 98 чиглэлээр ажлын байрны сургалтад хамрагдаж чадавхажсан. 2022 оны төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр бөөрний мэс засал судлал, эх барих эмэгтэйчүүдийн эхо, дурангийн онош зүй, жирэмсний хяналт, сэргээн засахын сувилахуй, хавдрын сувилахуй, хүүхдийн сувилахуй, эрчимт эмчилгээний сувилахуй зэрэг 12 чиглэлээр анхан болон хоёрдогч шатлалын эмнэлгийн эмч сувилагч нар суралцаж, эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай мэргэжлээр хүний нөөц бэлтгэгдэж байна.	100%
8		2.1.6. Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Нэгдсэн эмнэлгийн Сэтгэц наркологийн тасгаар дамжуулан 250-аас доошгүй иргэнд хүрч үйлчилсэн байна.	Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасагт архины шалтгаант сэтгэц, зан төрхийн эмгэгүүд оношоор нийт 10 хүн хэвтэн эмчлүүлж, сэтгэлзүйн тусламж, архины хордлого тайлах эмчилгээнд хамрагдсан. Амбулаториор нийт 126 иргэн сэтгэц наркологийн чиглэлээр тусламж үйлчилгээ авсан байна. Жаргалтай амьдрал төв нь 2022 онд 121 хүн хэвтэн эмчилж, өдрийн эмчилгээнд 50, өмнөх онд 295 хүн үйлчлүүлсэн бол энэ онд нийт 171 иргэн хамрагдаж, нөхөн сэргээх эмчилгээ, зөвлөгөө, сургалтын үйлчилгээ авсан байна. Эмчилгээнд хамрагдсан иргэдийн үр дүн 62 хувьтай, 10 хүн тутмын 6 нь бүрэн эдгэрч байна, 4 нь давтан эмчилгээнд хамрагдсан. 2022 онд эмчилгээнд орсон үйлчлүүлэгчдийн 106 нь архинаас бүрэн татгалзаж эдгэрсэн. Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний "Жаргалтай амьдрал" төвийн 2022 оны үйл ажиллагааны санхүүжилт 180.0 сая төгрөгийг 1 дүгээр улиралд, нэмэлт санхүүжилт 90.0 сая төгрөгийг 3 дугаар улиралд аймгийн Засаг даргын захирамжаар тус тус олгож, тогтмол зардал, эмч сувилагч, сэтгэл зүйч бусад ажилтнуудын цалин хөлс, тусламж үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэн,	100%
1	2	3	4	5	6

				цаашид уг төвийн үйл ажиллагаа нь тасралтгүй хэвийн үргэлжлэх боломж нөхцөл бүрдсэн. Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний Жаргалтай амьдрал төв нь эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2023 оны 02 дугаар сараас магадлан итгэмжлэлд хамрагдахаар бэлтгэл ажлаа хангаж байна.	
9		2.1.7. "Бид ёс зүйгээр манлайлна" уриалгат зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлэх	Анхан шатны нэгжүүдийн ёс зүйн багийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, чадавхжуулан, сургалт зохион байгуулна. Ёс зүй харилцаа хандлагын чиглэлээр үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэн эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагын сөрөг үзүүлэлтийг 2 хувиар бууруулна.	Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор өрөө гарган тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор "Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад эрүүл мэндийн салбарын 195 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхажсан. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос Жаргалант, Баянцагаан, Баянбулаг, Баянговь, Жинст, Баянлиг, Бууцагаан, Галуут, Гурванбулаг, Хүрээмарал зэрэг 10 сумын эрүүл мэндийн төв дээр ажиллаж, ёс зүйн багийн үйл ажиллагаатай танилцан, үнэлгээ хийж, зөвлөгөө зөвлөмж өгсөн. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хорооны 2021 оны ажлын тайланг дүгнэж, 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, багийн гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 дугаар тушаалын дагуу үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн 24 нэгж байгууллагууд улирал тутам авч, өөрийн байгууллагыг үнэлсэн дүнгээр нийт 6920 хүн хамрагдсанаас сэтгэл ханамжийн эерэг хувь 91.2 хувьтай үнэлэгдсэн. 2022 онд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа зөрчил бүртгэгдээгүй байна.	90%
1	2	3	4	5	6

10		2.1.8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмжийн хангалт 90-ээс дээш хувьд хүргэнэ.	Эрүүл мэндийн тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн салбарт 2022 онд улсын төсөв, эрүүл мэндийн яам, олон улсын төсөл, хөтөлбөр, хандив тусламжийн нийт 5.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн. Үүнээс дурдахад анхан шатны эрүүл мэндийн 16 нэгжид 312.0 сая төгрөгийн өртөг бүхий лабораторийн биохимийн болон гематлогийн анализаторыг нийлүүлэн хөдөөгийн иргэдийн оношилгоо шинжилгээний чирэгдлийг бууруулсан. Нэгдсэн эмнэлэгт “Эрүүл мэндийг дэмжих төв”- ийн 27 төрлийн 82 ширхэг 762.346.000 төгрөгийн өртөгтэй спирометр, авторефактометр, зүрхний ачаалалтай ЭКГ, тархины доплерын аппарат, чих хамар хоолойн иж бүрэн тоног төхөөрөмж, суурин эхо, ходоодны дуран, нүдний болрын хагалгааны аппарат зэрэг эмнэлгийн тоног төхөөрөмж болон аж ахуйн тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 90 хувьтай, анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 85, дундаж нь 87.5 хувьтай болж, өмнөх жилээс 2 хувиар нэмэгдэн, иргэд орон нутагтаа оношилгоо эмчилгээний өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ авах боломж нөхцөл бүрдээд байна.	100%
11		2.1.9. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын явцыг 80 хувьд хүргэх.	Амбулаторийн барилгын явц 80 хувьд хүрсэн байна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 9.4 тэрбум төгрөгийн өртөгтэй Амбулаторийн шинэ барилгын ажлыг "Рокпэйнт групп" ХХК гүйцэтгэж, одоогийн байдлаар барилгын суурь болон каркас угсралт бүрэн хийгдэж дууссан. Өрлөгийн ажлыг эхлүүлсэн, 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Уг барилга ашиглалтад орсноор аймгийн 89.0 мянга гаруй хүн амд хоёрдогч шатлалын өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, стандартын шаардлагад нийцсэн ая тухтай орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэх юм.	70%
12		2.1.10. Заг, Галуут сумын Эрүүл мэндийн төвийн Халдвартын тасгийн эмнэлгийн барилгыг засварлах	Заг, Галуут сумдын халдвартын тасгийн барилгын засварын ажил хийгдэж дууссан байна.	Галуут сумын эрүүл мэндийн төвийн халдвартын эмнэлгийн 356.0 сая төгрөгийн засварын ажлын тендерт “Ар жаргалантын гол” ХХК шалгарч гэрээ байгуулан, 2022 онд орсон 100.0 сая төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэл бүрэн хийгдсэн. 2023 онд үлдэгдэл 256.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, барилгын ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Галуут сумын ЭМТ-д засвар үйлчилгээ хийгдсэнээр ахмадын сэргээн засах төвийг байгуулж, өрөө тасалгааны хүртээмжээ сайжруулан,	90%
1	2	3	4	5	6

				сэргээн засах эмчилгээг өргөжүүлэхээр ажиллаж байна. Заг сумын эрүүл мэндийн төвийн 87.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дээврийн засварын ажлын тендерт “Жаргантайн хөх тариа” ХХК шалгарч, барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай, улсын комисс хүлээж авсан. Уг барилгыг стандартад нийцүүлэн засварласнаар иргэдийн тусламж үйлчилгээ авах ээлтэй орчин нөхцөл бүрдээд байна.	
13		2.1.11. Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эмнэлэг барих	Оточ номгон эмнэлгийн барилгын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэсэн байна.	Аймгийн төвийн Оточномгон өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгын ажлын гүйцэтгэгчээр “Базардарь” ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Нийт 827.752.000 төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн. Тус өрхийн эмнэлэг ашиглалтад орсноор 7300 гаруй хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ээлтэй орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэж, аймагтаа өрөө тасалгааны хүртээмжтэй, стандартад нийцсэн жишиг өрхийн эмнэлэгтэй болж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан.	100%
14	2.2. Идэвхтэй амьдрал – Чийрэг иргэн	2.2.1. Усан бассейний бүхий цогцолборыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	Спорт цогцолбор хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр 100 хувь хангагдана.	Усан бассейний бүхий спорт цогцолборыг 2022 оны 12 сард улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. Монголын Бадминтоны холбоонд хүсэлт хүргүүлж шинэ цогцолборт шаардлагатай Бадминтоны дэвсдэг шал, бөмбөг, цохиур зэргийг нийт 15.0 сая төгрөгийн өртөг бүхий хэрэглэл материалыг шийдвэрлэн цаашид аймаг орон нутаг, бусад дэмжлэгтэйгээр тоног төхөөрөмжийн хангалтыг хийж байна.	30%
15		2.2.2. Баянхонгор сумын төв цэнгэлдэх хүрээлэнд хөнгөн атлетикийн талбай байгуулах	Хөнгөн атлетикийн зориулалттай талбай бий болсон байна.	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн хөнгөн атлетикийн талбайг байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Даяар трейд” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нийт 148.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй талбайн ажлын гүйцэтгэл 100 хувьтай хийгдсэн. Хөнгөн атлетикийн талбайтай болсноор иргэд, хүүхэд, залуучуудын энэ спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдсэн.	100%
16		2.2.3. Бадминтон, үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	Бадминтон, үндэсний бөхийн спортын төрлийн хөгжлийг дэмжиж, улсын аварга шалгаруулах тэмцээн байгуулагдсан байна.	Бадминтоны өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 04 дүгээр сард зохион байгуулж, 10 аймаг, 3 клубийн 346 тамирчин оролцсон. Шинээр хөгжиж байгаа Бадминтоны спортоор 140 гаруй хүүхэд хичээллэж байна. Бадминтон Крикетийн холбоотой хамтран 19.0 сая төгрөгийн хэрэглэл материалаар хангасан. Үндэсний бөхийн өсвөр үеийн Монгол улсын аварга шалгаруулах барилдааныг 09 дүгээр сард 3 насны ангиллаар зохион байгуулж, 21 аймаг 9 дүүрэг, 30 байгууллагын 90 гаруй бөх оролцсон. Тус арга хэмжээнд орон	100%
1	2	3	4	5	6

				нутгийн төсвөөс 15 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж ажилласан.	
17		2.2.4. Спортын холбоодыг дэмжих	5-аас доошгүй спортын холбоодод дэмжлэг үзүүлсэн байна.	Аймагт үйл ажиллагаа явуулдаг 14 спортын холбоо улс, бүс, аймгийн аварга шалгаруулах 16 төрлийн тэмцээнийг зохион байгууллаа. “Үндэсний шагайн харвааны холбоо”, “Байт харвааны холбоо”, “Хонгорын хийморь 3х3” сагсан бөмбөгийн холбоо, “Хонгорын өглөө” Бадминтоны холбоо, “Үндэсний шагайн наадгайн холбоо”, Үндэсний сурын холбоо” зэрэг 6 спортын холбоонд үйл ажиллагаа явуулах байрыг шийдвэрлэж ажилласан.	100%
18		2.2.5. Ламын гэгээний их тойром шагайн харваа зохион байгуулах	Ламын гэгээний их тойром шагайн харваа зохион байгуулагдсан байна.	Ламын гэгээний их тойром шагайн харвааг 08 дугаар сард зохион байгуулж, 16 аймаг, 3 дүүргийн 52 баг, хавчаахай харвааны 32 багийн нийт 700 гаруй тамирчид оролцож амжилттай зохион байгуулсан.Шагайн харваан наадмыг зохион байгуулснаар 2021 онд цуваа харваагаар 15-20 харваач тогтмол хичээллэдэг байсан бол 2022 онд 25-30 харваач хичээллэж хичээллэгсдийн тоо нэмэгдэж улс, бүс аймгийн чанартай тэмцээн уралдаанд оролцох тамирчдын ур чадвар дээшилсэн байна.	100%
19		2.2.6. Шинэжинст сумд спорт заал барих	Спорт заалны барилга баригдаж дууссан байна.	Шинэжинст сумын спорт заалны барилгын ажлын гүйцэтгэгчээр “Буян арвижих” ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл 80 хувьтай байна	70%
20		2.2.7. Дөвөнтийн заалны их засварыг хийх	Дөвөнтийн заалны их засварын ажлын гүйцэтгэлийг 70 хувьд хүргэсэн байна.	Дөвөнтийн заалны их засварын ажлын гүйцэтгэгчээр "Буян арвижих" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувь хийгдсэн. Заалны засвар бүрэн хийгдэж дууссанаар иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдэж, тоо нэмэгдэж байна.	100%
21	2.3. Боловсролын чанар хөгжлийн тулгуур	2.3.1. Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн барилга барих	Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.	Улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2022-2023 онд хуучин 90 хүүхдийн актлагдсан барилгыг буулгаж шинээр барих ажил 2022 онд 700 сая төгрөг төлөвлөгдсөн боловч хэмнэлтийн хуулиар хасагдаж 140 сая төгрөгийн санхүүжилтээр “Шинэ өлгийн зам” ХХК-тай шууд гэрээ байгуулан цэцэрлэгийн хуучин барилгыг бүрэн буулгаж, шинээр барих 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын суурийг /кундамент/ хийж гүйцэтгэсэн.	90%
22		2.3.2. Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгад их засвар	Цэцэрлэгийн насны 220 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор сумын улсын тэргүүний 4 дүгээр цэцэрлэгийн барилгын дотор их засварын ажлыг 2022 оны 06 дугаар сараас 10 дугаар сарын 01 хүртэл хийж дуусган	100%
1	2	3	4	5	6

		хийх	хамрагдах таатай орчныг бүрдүүлнэ	улсын комисст хүлээлгэн өгсөн. Их засвараар анги, коридорын бүх хаалга, цонх, шал, цахилгаан, сантехникийн их засвар, гал тогооны агааржуулалт, хийж ариун цэврийн байгууламжийг иж бүрэн сольсон.	
23		2.3.3. Гурванбулаг сум, Баянхонгор сумын Шаргалжуут тосгоны сургуулийн хичээлийн байрны барилгыг барих	Гурванбулаг сумын сургуулийн 160 хүүхдийн хичээлийн байрны барилгыг ашиглалтад оруулж сурагчдын суралцах орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Шаргалжуут тосгоны сургуулийн барилгын ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэнэ.	Гурванбулаг сумын 160 хүүхдийн суудалтай хичээлийн байрны барилгын ажил 3 тэрбум 105.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2021 онд 928.8 сая төгрөгийн, 2022 онд 1 тэрбум 651.5 сая төгрөгийн санхүүжилтээр “Гурванбулаг сод” ХХК гүйцэтгэж байна. Сургуулийн барилгын суурийн ажил хийгдэж 1, 2 дугаар давхрын багана цутгалт өрлөг, гадна шавар, хөөс хийгдэж цонх суурилагдсан дээвэр дууссан, төв хаалга хийгдсэн гадна явган хүний зам 40 хувьтай хийгдэж, халаалтын шугамын ажлын явц 80 хувьтай байна. Баянхонгор сумын 8 дугаар баг Шаргалжуут тосгоны 240 хүүхдийн суудалтай хичээлийн байрны 2 тэрбум 196.2 сая төгрөгийн төсөвтэй барилгын ажлыг “Очиртзаан” ХХК хийж гүйцэтгэж суурийн ажил хийгдэж 1, 2 давхрын карказын цутгалт хийгдсэн ажлын явц 50 хувьтай байна.	70%
24		2.3.4. Баянхонгор сумын 5-р сургуулийг цэвэр усны шугамд холбох	Сургуулийг цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангана.	Баянхонгор сумын 5 дугаар сургуулийг цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээнд холбож эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангасан.	100%
25		2.3.5. Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засварыг хийх	Богд сумын 320 хүүхдийн суралцах орчин нөхцөлийг сайжруулна.	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Богд сумын ЕБС-ийн 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрны гадна фасадын засварыг “Түйн долгио” ХХК 2022 оны 05 дугаар сарын 07-31-ний хооронд хийж гүйцэтгэсэн. Тус компани ажлыг чанартай хийж гүйцэтгэсэн бөгөөд нэмэлтээр цонхны тавцангийн хөмсөг, спорт заалны хана болон сэндвич хавтан 2-ын хоорондох хэсгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Барилгын гадна фасадын засварын нийт өртөг 158.782.345 төгрөг, үүнээс 2022 онд 75.400.000 төгрөг авсан. 2023 онд 83.382.346 төгрөгийн санхүүжилт үлдсэн. 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 2022/11 тоот барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарч хүлээлгэн өгсөн болно.	100%
26		2.3.6. Жаргалант сумын сургуулийн их засвар	Жаргалант сумын сургуулийн их засвар хийгдсэн байна.	Жаргалант сумын сургуулийн сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэлийн заал болон хүнсний агуулахын их засварыг “Ерөөл нэмэх” ХХК улсын төсвийн 120 сая төгрөгөөр хийж гүйцэтгэн улсын	100%
1	2	3	4	5	6

				комисст хүлээлгэн өгсөн.	
27		2.3.7. Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийх	Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийгдсэн байна.	Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгад их засварын ажлыг “Есөн-од” констракшн ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулан хийж байна. Ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна.	70%
28		2.3.8. Бууцагаан сумын хуучин сургуулийн барилгын дээврийн их засварыг хийх	Бууцагаан сумын хуучин сургуулийн барилгын дээврийн их засварыг хийгдэж дууссан байна.	Сургуулийн /хуучин/ 320 хүүхдийн хичээлийн байрны дээврийн их засварын 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт “Алегротовер” ХХК- шалгарч засварын ажлыг 100 хувийн гүйцэтгэлтэй хийж дууссан.	100%
29		2.3.9. Баянговь сумын цэцэрлэгт хүрээлэнг засварлах	Иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ.	Баянговь сумын наадмын талбайн их засварын ажлыг 2022 оны орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр Баялаг-Өлзий ХХК үзэгчдийн суудал, тугны суурь, зүлэгжүүлэлт зэрэг бүх засварыг хийж гүйцэтгэсэн. Мөн эзэмшигчийг тогтоолгож хөрөнгийг орлогод авсан	100%
30		2.3.10. Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	Нийт багш нарын 50 хувь /ЕБС-500 багш, СӨБ-100 багш/-ийг зөөврийн компьютероор хангах, 5 сургуульд контент боловсруулах лаборатори байгуулна.	Багш нарыг зөөврийн компьютероор хангах тендерт SUMMET ХХК шалгарч гэрээ байгуулан 600 компьютерыг дагалдах хэрэгслийн хамт аймгийн Засаг даргын 2022 оны А/699 дүгээр захирамжаар байгуулсан ажлын хэсэг хүлээн авч ЕБС, хүүхдийн цэцэрлэгүүдэд хуваарилсан. Галуут, Эрдэнэцогт, Богд, Баянхонгор сумын 5 дугаар сургуульд бичил лаборатори олгосон. Мөн аймгийн хэмжээнд цахим ангитай болгох хүрээнд ЕБС-ийн 31 сургуульд нийт 963.5 сая төгрөгийн санхүүжилтийг сургууль тус бүрд хүүхдийн тооноос хамаарч хуваарилалт хийсэн.	100%
31		2.3.11. Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмж	Хоцрогдолд өртсөн сурагчдын сурах орчин нөхцөл сайжирч, сурлагын хоцрогдлыг бууруулна.	Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих, хоцрогдолд өртсөн сурагчдын сурах орчин нөхцөлийг сайжруулах, багш нарын дижитал арга зүй, ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтын орчин цагийн танхимыг бий болгох зорилгоор “Дижитал танхим” хөтөлбөр, төслийг хэрэгжүүлж Баянхонгор сумын “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм”, Соого сейкео ерөнхий боловсролын сургуулиуд, Бууцагаан, Бөмбөгөр, Өлзийт, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуульд их бүрэн мэдээллийн технологийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлж сургалтын танхим байгуулсан.	100%
32		2.3.12. Сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого,	Хүүхэд хамгааллын бодлого, орчны стандартын	Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулан аймгийн нийт сургуулиудад хүргүүлж “5Х”-ийн зорилтот арга хэмжээг ГБХЗХГ-тай хамтран зохион байгуулж 33 сургуулийн 405 багш, ажилтан,	100%
1	2	3	4	5	6

		орчны хангах	стандартыг	хэрэгжилтийг 60-аас дээш хувьд хүргэнэ	“Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа” арга хэмжээний хүрээнд 4 зорилт 15 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 29714 насанд хүрэгч, 926 сурагчдад хүрч ажилласан. Нөлөөллийн арга хэмжээний үр дүнд 27075 эцэг эх буюу нийт эцэг эхчүүдийн 29.9% нь хүмүүжлийн эерэг аргын талаар мэдлэгтэй болсон, сургууль, цэцэрлэгийн “Хүүхэд хамгааллын баг”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 145 хүнд, хүүхдийн хөгжил, хамгааллын талаар мэдээлэл өгөх сургалтыг 270 хүнд, үе тэнгийн дээрэлхэлтийн чиглэлээр 75 сургагч багш бэлтгэгдсэн, Хүүхдийн эрсдэлийн нөхцөл байдлыг үнэлэх мэдлэг, чадвар эзэмших, хүүхэдтэй ажиллах мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйчдэд дэмжлэг үзүүлэх, зорилготой “ЭКО ЗУРАГЛАЛ, ГЕНОГРАММ, АМЬДРАЛЫН ЗУРАГ” зэрэг аргачлалын арга зүйг эзэмшүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Баянхонгор аймгийн ЕБС-ийн 31 нийгмийн ажилтан , цэцэрлэгийн арга зүйч 21 нийт 52 хүн хамрагдаж мэдлэг мэдээлэлтэй болсон. Үе тэнгийн дарамт хүчирхийллийн эрсдэлийг бууруулах, хүүхдийн сөрөг араншин, зан үйл хандлагад эергээр нөлөөлөх зорилго бүхий Банхар арт терапи төсөл хэрэгжсэн. Баянхонгор сумын 10 сургуулиас 120 орчим эцэг эх, 80 орчим багш, нийгмийн ажилтан сургуулийн удирдлага 75 хүүхдүүд оролцон сургагч багшаар бэлтгэсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/270 дугаар захирамжаар "Хүүхэд хамаатай орчин хяналт шалгалт хийж, аюулгүй байдлыг хангуулах тухай" захирамжаар ажлын хэсэг байгуулж, ажлын удирдамжийн дагуу зохион байгуулж хэрэгжилтийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт тайланг хүргүүлж ажилласан.	
33		2.3.13. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх.	Гурванбулаг, Хүрээмарал, Богд сумын сургууль, цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.	Эрдэнэт үйлдвэрийн санхүүжүүлэлтээр БШУЯ -наас хэрэгжүүлж буй стандартын ариун цэврийн байгууламж хийх ажлын 1,2 дугаар ээлжийн Баянбулаг, Заг, Баян-өндөр, Бөмбөгөр сумын нийт 9 объектын ус ариун цэврийн байгууламжийн ажлыг Модерн Хас ХХК гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өгч сургууль цэцэрлэг, дотуур байрыг бүрэн ашиглаж байна. 3 дугаар ээлжийн Гурванбулаг сумын сургууль, Хүрээмарал сумын дотуур байр, Богд сумын сургууль, Шинэжинст сумын дотуур байрны ус ариун цэврийн байгууламжийн зураг төсөл хийгдэж дуусан тендерт “Ноёдын тур” ХХК шалгаран судалгааны ажил хийгдэж байна.	70%	
1	2	3	4	5	6	

34		2.3.14. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах.	Галуут, Баянлиг, Бөмбөгөр, Жаргалант, Шинэжинст сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилнэ.	Аймгийн хэмжээний 33 сургуулийн 72,7 хувь зориулалтын хоол үйлдвэрлэлийн газартай бөгөөд 2022 онд Жаргалант, Галуут, Баянлиг, Бөмбөгөр, Шинэжинст сумууд тоног төхөөрөмжөө шинэчилж сургуулийн хүүхдийн үдийн хоолны чанар стандартыг хангасан.	100%
35		2.3.15. Бага насны хүүхдийн цогц хөгжил хамтын ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх.	Салбар дундын уялдаа холбоог хангаж стратегийн төлөвлөгөөний биелэлтийг 55-аас дээш хувьд хүргэнэ.	Аймаг сумын эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгааллын асуудал хариуцсан 25 хүнийг сургагч багшаар бэлтгэн, 336 эцэг эхэд бага насны хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, асаргаа хамгааллын мэдлэг чадвар олгох, гэр бүлдээ дадал болгох сургалтыг зохион байгууллаа. Бөмбөгөр, Эрдэнэцогт сумын цэцэрлэгийг түшиглэн алслагдсан малчдын болон зорилтот бүлгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, асаргаа хамгаалал, хоол тэжээлийн талаар цогц ойлголт өгөх сургалт зохион байгуулан зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлэх “Эцэг эх”-ийн клубийг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 14.3 сая төгрөгөөр байгуулж, давхардсан тоогоор 820 эцэг эх асран хамгаалагч нарт үйлчилгээ үзүүлсэн. ЭМГ, БШУГ, ХГБЗХГ хамтран 6 төрлийн 13 зурагт хуудас, Гэрийн эзэгтэйн бага насны хүүхдэд зориулсан хоолны жор, Бага насны хүүхдийн эрх хамгаалал, Хүүхдийн хөгжилд таны оролцоо гарын авлагыг бэлтгэн цэцэрлэгүүдэд хүргүүлж 2100 эцэг эх асран хамгаалагч нарт хүргэгдэж, салбар дундын уялдааг сайжруулах төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд бүрэн хэрэгжлээ.	100%
36		2.3.16. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Нийт багш нарын 40 хувийг чадавхжуулах сургалтад хамруулж багш нарын тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж урамшуулна	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны "Хөтөлбөр төлөвлөгөө баталж хэрэгжилтийг хангах тухай" А/07 дугаар тушаалаар баталсан “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/596 дугаар захирамж хэрэгжиж байна. Тайлант онд аймгийн хэмжээнд Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах чиглэлээр мэргэжлийн болон заах арга, дидактикын сургалтад ерөнхий боловсролын 900, СӨБ-ын 240, 2 дахь жилдээ ажиллаж байгаа 50 гаруй багш сургалтад хамрагдсан нь нийт багш нарын 90 хувийг хамарч байна. Бага насны хүүхдийн онцлог, хүүхдийг хөгжүүлэх, үнэлэх, багшийн хөгжил болон сургалтын орчны чиглэлээр нийт 8 сэдвийн хүрээнд сургалт зохион	100%
1	2	3	4	5	6

				байгуулснаар эрхлэгч 129 (давхардсан тоогоор), арга зүйч 48, бүлгийн багш 372, туслах багш 113 хамрагджээ. Эдгээр сургалтын үр дүнд хүүхдийн хөгжилд ахицын үнэлгээ, шинжилгээ хийгдлээ. Мөн багш нар 24 контент боловсруулж СӨБ-ийн багш нарын бид хамтдаа бүлгэмд байршуулж арга туршлагаа түгээн дэлгэрүүлсэн байна. “Блюпринт боловсруулах арга зүй, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх”, “Хичээл, сургалтын үр дүнд цахим технологи ашиглах арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, ЕБС-ийн сургалтын менежерүүд Улаанбаатар хотод чадваржуулах сургалтад хамрагдсан. Аймгийн хэмжээний багш нарын 90 хувь чадваржуулах сургалтад хамрагдсан нь өмнөх оныхоос 40 хувиар нэмэгдсэн үзүүлэлт байлаа.	
37		2.3.17. Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргаж болзол хангасан багш сурагчдыг шагнаж урамшуулах	Амжилтаа бататгаж, багш сурагчийг шагнаж урамшуулна.	Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах, амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах зорилгоор сорил шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулж “Сорил-1” шалгалтыг 2-р сард, “Сорил-2” шалгалтыг 3-р сард “Сорил-3” шалгалтыг 4-р сард, “Сорил-4” шалгалтыг 5-р сард тус тус зохион байгуулсан. Энэхүү шалгалтаар анхны оноо буюу гүйцэтгэлийн хувь нь “сорил-1”-ээс ахисан 107 сурагч, бэлтгэсэн сурагчдын гүйцэтгэлийн дундаж хувь нь ахисан 5 багшийг батламж, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Сургуулиудын гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт 10 хичээлийн нийлбэрээр 8,4 хувиар өссөн. Ялангуяа бүх хичээлүүд дээр арифметик дундаж, медиан өссөн нь гүйцэтгэл муу байсан масс хэсэг рүү анхаарал хандуулсны үр дүн гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл өмнөх сорил шалгалтыг суурь түвшин болгож авахдаа гүйцэтгэлийн хувийг 4 завсарт хувааж, завсар тус бүр дэх сурагчид руу анхаарч чадсан байна. Сорилын урамшуулалд нийт 16520,0 зарцуулсан.ЭЕШ-ын дүнгээр улсад 4 дүгээр байранд орж, Аймгийн ИТХТ-ийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор баталсан журмын болзлыг хангасан 10 багшид 17,5 сая төгрөг, 8 сурагчдад 7.8 сая төгрөг нийт сум, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 41,800 сая төгрөг зарцуулсан багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж тэднийг цалин хөлсийг нэмэгдүүлж, ажлын үр дүнг гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоог бий болгоход зохих хувь нэмэр орууллаа.	100%
38		2.3.18. Төрийн албан хаагч, иргэдийн	Төрийн албан хаагчдын монгол бичгийн	Төрийн албан хаагчдын монгол хэл бичгийн чадварыг оношлох, гарааны түвшнийг тогтоох сорилд 20 сумын 1203 албан хаагч	
1	2	3	4	5	6

		үндэсний бичгийн чадварыг сайжруулах, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах	түвшинг ахиулж хэрэглээнд сургах, монгол бичгийн орчин бий болгоно.	хамрагдсан. хамрагдаж шалгалтын гүйцэтгэлийн хувь 60,5 хувьтай дүгнэгдлээ. Монгол хэл, бичгийн багш нарын онолын мэдлэг, мэргэжил арга зүйн захиалгат сургалтыг МУБИС-ийн Монгол судлалын сургуультай хамтран аймаг, сумын 65 багшид сургалт зохион байгуулсан. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”- ыг хэрэгжүүлэх зардал олгох тухай А/254 дүгээр захирамжаар ЕБС-ийн багш, иргэдийн дунд Босоо бичгийн сургалт зохион байгуулж, “Тэргүүний уншигч” шалгаруулах үндэсний бичгийн хурдан уншлагын уралдаанд 14 сум, аймгийн ЕБС-аас шалгарсан нийт 114 сурагч оролцож, 2 ангилал тус бүрээс шалгарсан нийт 10 сурагчийг улсын уралдаанд оролцох эрх, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав. Энэхүү арга хэмжээнд аймгийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээс 5 сая төгрөгийг олголоо. Төрийн байгууллагын 160 гаруй архив, бичиг хэргийн ажилтнуудад цахим бичвэрийн программыг таниулах сургалт хийсэн.	70%
39		2.3.19. Иргэдийн тасралтгүй боловсролын цахим үйлчилгээг өргөжүүлэх	Танхимын болон цахим контентоор 40000 гаруй иргэнд үйлчилнэ. 5 төрлийн контентыг гаргаж, 5-аас багагүй клуб, сонирхлын бүлгийг дэмжинэ.	Насан туршийн боловсролын төв амьдрах ухаан, гэр бүл, иргэний, гоо зүй, ёс зүй, шинжлэх ухааны боловсрол гэсэн үндсэн агуулгаар 886 удаагийн сургалтаар 43270 иргэнд, 460 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаагаар 30485 иргэнд боловсролын үйлчилгээг үзүүлсэн байна. Боловсролын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 65 хувь нь эмэгтэй, 49 хувь нь хүүхэд, 25,3 хувь нь төрийн албан хаагч, 8,1 хувь нь малчин, 10,1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 5 хувь нь ажилгүй, 2,4 хувь нь тэтгэврийн насны иргэд байна. Иргэдийг зөв хандлага, зөв үйлд уриалсан 543 постер, 229 шторк, 290 видео бичлэгийг гарган орон нутгийн цахим сүлжээгээр олон нийтэд хүргэн тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн боловсролын үйлчилгээг үзүүлсэн. НТБ-ын нэгжүүд “Уран бичлэг”, “Үсчин”, “Гоо сайхан”, “Уран уншигч” зэрэг 10 гаруй дугуйланг хичээллүүлсэн.	100%
40		2.3.20. "Өрхийн хөгжлийг дэмжих" арга хэмжээг хэрэгжүүлэх	Өрхийг хөгжүүлэх төлөвлөгөөг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран боловсруулж.	Аймгийн Засаг даргын 2022 оны “Өрхийн хөгжил цогц арга хэмжээг зохион байгуулах тухай” А/253 дугаар захирамжаар арга хэмжээний удирдамж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд хөдөөгийн 19 сумын нийт 240 өрх сонгон ажилласан.	100%
1	2	3	4	5	6

			239 өрхийг хамруулна	Сонгогдсон өрхийн нийт 1033 гишүүд нь насны ангиллаар 0-2 насны 92, 3-5 насны 132, 6-18 насны 334 хүүхэд, 19-24 насны 105, 25-59 насны 353, 60-аас дээш насны 17 иргэн байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй-36, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагддаг-128 хүн байна. 240 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийж, өрх бүрийн төлөвлөгөөг гаргуулан ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 2-5 насны 100 хүүхэд ээлжийн бүлгээр /танхимаар/, малчин өрхийн 32 хүүхэд нүүдлийн бүлгийн үйлчилгээнд хамрагдсан. Сургуулийн насны 334 хүүхэд байгаагаас 264 хүүхэд нь ЕБС-д, 70 хүүхэд нь суурь боловсрол эзэмшээд мал маллах, хувиараа хөдөлмөр эрхэлж байна. СӨБ-ийн болон сургуулийн гадна байгаа хүүхэд байхгүй. Сонгогдсон өрхөд гэр бүлийн боловсрол, санхүү, тогтвортой хөгжил, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, харилцаа хандлага, асуудлыг шийдвэрлэх, холбоо тогтоох, стресс менежмент зэрэг агуулгаар 32 удаагийн сургалт явуулж 1283 гишүүдийг хамруулсан бол 71 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаанд 904 гишүүд хамрагдлаа.	
41	2.4. Шинжлэх ухаан технологи, инноваци	2.4.1. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалт зохион байгуулах	Аж ахуй эрхлэлтийн сургалтад 150 иргэнийг хамруулж бизнесийн төсөл төлөвлөгөө боловсруулах мэдлэг олгоно.	"Хөгжлийн шийдэл" төрийн бус байгууллагатай хамтран аж ахуй эрхлэлтийн "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтад хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 160 иргэн, төсөл хөтөлбөрт хамрагдсан 174 иргэн, нийт 391 иргэнийг хамруулж чадавхжуулсан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 8.924.000 төгрөгийг зарцуулсан.	100%
42	2.5. Халамжаас - Хөдөлмөрт	2.5.1. Гарааны бизнес эрхлэгч залуучуудын үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	"Start-up" арга хэмжээнд хамрагдсан залуусын дунд уралдаан зохион байгуулж, шилдэг төсөлд дэмжлэг үзүүлнэ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Старт-ап" арга хэмжээг 18-34 насны 70 гаруй залуучуудыг хамруулан 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Шилдэг "Старт-ап" багаар модон эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Б.Гончигдорж ахлагчтай баг шалгарч, эргэн төлөгдөх нөхцөлгүй 10 сая төгрөгийн дэмжлэг олгосон. Ингэснээр 2 өрхийн орлогыг нэмэгдүүлж, 3 байнгын ажлын байрыг бий болгосон.	100%
43		2.5.2. Ахмад настан, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өрх толгойлсон эцэг,		
1	2	3	4	5	6

			эхчүүд, 40-өөс дээш насныхан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 130-аас доошгүй иргэнийг хөдөлмөр эрхлэлтээр дэмжинэ	Хүн амын бүлгүүдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдэд 3394 иргэн хамрагдаж, 1800 иргэн ажлын байраар хангагдаж 1.691.6 сая төгрөгийг зарцуулсан. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт Хөгжлийн бэрхшээлтэй 82 иргэний бизнес төсөл хүлээн авч 38 иргэний төслийг дэмжиж 144 сая төгрөгийн санхүүжилт, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 8 иргэнд ажлын байрны түрээсийн хөнгөлөлт болох 9.6 сая төгрөгийн санхүүжилт, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг байнгын ажлын байранд 12 сараас дээш хугацаанд ажиллуулсан 5 аж ахуй нэгж байгууллагад 25.2 сая төгрөгийн урамшуулал, хөгжлийн бэрхшээлтэй 7 иргэнийг байнгын ажлын байраар хангаж, ажлын байранд гарахад нь дадлагажуулж, хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг хэрэгжүүлсэн 3.5 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон. Ахмад мэргэжилтний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 62 иргэний төслийг хүлээн авч ажлын хэсгийн шийдвэрээр 38 ахмадын төсөлд 125.0 сая төгрөгийн дэмжлэг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн ахмадын зөвлөх арга хэмжээнд 26 ахмадын материалыг хүлээн авч 5520 цагийн 24.8 сая төгрөгийн урамшуулал, хүүхэд хамгаалагч арга хэмжээг Цагдаагийн газартай хамтран гавьяаны амралтад гарсан цагдаагийн 2 ахмадтай гэрээ байгуулан ажиллаж, 3.4 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгож ажилласан.	100%
44		2.5.3. “Хүмүүнлэгийн ордон”-ы тохижилт, үйлчилгээг сайжруулах (үйл ажиллагааны зардал)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг хангаж, эрүүл мэнд, сэтгэл засал, боловсрол, нийгмийн суурь үйлчилгээнүүдэд хамрагдах таатай орчныг бүрдүүлнэ.	Хүмүүнлэгийн ордонд хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэх 17 газар үйл ажиллагаагаа явуулж давхардсан тоогоор 2960 иргэн эрүүл мэндийн болон сэтгэл засал, зөвлөгөө мэдээллийн үйлчилгээ авсан. Энэ нь өмнөх оноос 1986 хүнээр өссөн байна. Мөн тусгай хэрэглэгдэхүүн худалдах дэлгүүрийг нээн ажиллуулж хөгжлийн бэрхшээлтэй хүн тэргэнцэр, хөтөвч, таяг, таягны зөөлөвч зэрэг тусгай хэрэглэгдэхүүнийг нэг цэгээс хүндрэл, чирэгдэлгүй авах нөхцөл бүрдсэн. Хүмүүнлэгийн ордны үйл ажиллагааны зардалд Орон нутгийн төсвөөс 110.0 сая төгрөг, засвар үйлчилгээ хийж, ажлын байр бий болгоход 19.0 сая төгрөг, нийт 129.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100%
45		2.5.4. Аймгийн бүтээн байгуулалтын ажил ажил хайгч бүртгэлтэй	Аймгийн бүтээн байгуулалтын ажилд 500-аас доошгүй	Аймгийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, хог хаягдал ангилан ялгах, засмал зам дагуух хайрга чулууг түүх, динозавртай паркийн хашааг буулгах	100%
1	2	3	4	5	6

		иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	иргэдийг хамруулна.	зэрэг ажлын хүрээнд 1714, хувийн аж ахуйн нэгж, байгууллага болон бусад хөтөлбөр, төслийн хүрээнд 463, нийт 2177 ажлын байрыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж мэдээлж ажилласан. Түр ажлын байр бий болгоход 550.0 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан. Шинээр бий болсон ажлын байр 692 буюу 31.7 хувийг байнгын ажлын байр эзэлж байна.	
46		2.5.5. Хүнсний эрхийн бичигт хамрагдсан иргэдэд хяналт хийж мониторинг хөдөлмөрт бэлтгэх	Хөдөлмөр эрхлэх боломжтой иргэдийн 20-оос доошгүй хувийг байнгын болон түр ажлын байраар хангана	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд хүнсний эрхийн бичиг олгох журмыг шинэчлэн баталсны дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 1171 өрхийн 5985 гишүүн иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласан. Дээрх иргэдийн 3295 нь насанд хүрэгч иргэд, 2690 нь хүүхэд байна. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд шинээр 19 өрхийн 86 иргэнийг, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа өрхөд шинэ төрсөн 36 хүүхдийг тус тус үйлчилгээнд хамруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны "Хүнсний эрхийн бичиг олгох шинэчилсэн журам"-ын дагуу 23 өрхийн 145 гишүүн иргэний үйлчилгээг зогсоож, 108 өрхийн 631 гишүүн иргэний үйлчилгээг түдгэлзүүлэн, үйлчилгээнээс хассан. "ХАЛАМЖААС- ХӨДӨЛМӨРТ" зорилтын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа иргэдийн нарийвчилсан судалгааг шинэчлэн гаргахад хөдөлмөрийн насны 1100 иргэн байгаагаас ажил идэвхтэй хайгч 609 иргэн байна. Үүнээс: Байнгын ажлын байранд 16 иргэн, аймгийн бүтээн байгуулалтын ажилд буюу мод тарих, явган замын өнгөт хавтан суурилуулах, хог хаягдал ангилан ялгах, цэвэрлэх, улирлын чанартай түр ажлын байранд 287 иргэнийг тус тус зуучилж, ажлын байраар хангасан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 180, аж ахуй эрхлэлт, төсөл хөтөлбөрийн сургалтад 35, амьдралын итгэл үнэмшил олгох, хөдөлмөрт бэлтгэх, авьяасыг нь дэмжих бүлэг үүсгэх сургалтад 157, нийт 372 иргэнийг чадавхжуулж, өдөрлөг яармаг, бусад арга хэмжээнд 329 иргэнийг чадавхжуулж, Олон нийтийн оролцоотой төсөл хөтөлбөрийн бүлгийн төсөлд 1 иргэнийг хамруулж 1500,0 төгрөгийн буцалтгүй дэмжлэг үзүүлсэн. Дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 1136 иргэн хамрагдсан байна. Ингэснээр зорилтот өрхийн гишүүн-иргэний амьдралын хэвшилд нь тодорхой өөрчлөлт орж, иргэдийн амьжиргаанд нь зохих дэмжлэг болж чадсан.	100%
1	2	3	4	5	6

				Баян-Өндөр, Богд, Жинст сумууд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаггүй сум болсон.	
47		2.5.6. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1800 ахлах ангийн сурагчид, хүүхэд, ажил хайж буй ажил хайж буй 750 залуучуудыг залуучуудад ажил хамруулна мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг зохион байгуулах	Ерөнхий боловсролын ахлах ангийн 1800 хүүхэд, ажил хайж буй 750 залуучуудыг хамруулна	"Давуу талдаа суурилсан мэргэжил сонголт" сургалтыг ерөнхий боловсролын 9 сургуулийн ахлах ангийн 1000 сурагчдад бүлгийн хэлбэрээр, идэвхтэй ажил хайж буй хөдөлмөрийн насны 1270 залуучуудад бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр, нийт 2270 хүүхэд, залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн талаарх танилцуулга, сургалтуудыг зохион байгууллаа. Ингэснээр хүүхэд, залуучууд ажил, мэргэжлээ зөв сонгох, чиг баримжаатай болсон.	100%
48		2.5.7. Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн даатгалд баталгааг хангана.	Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 280 иргэдийг, сайн дурын даатгалд шинээр хамруулна	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалаа. Гэрээний хэрэгжилтийн дундаж 95.6 хувьтай байна. Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч мөн ажил хөдөлмөр эрхэлдэггүй 5606 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 1104 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Нийт 6710 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 3486, хувиараа хөдөлмөр эрхлэгч 956, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 427, оюутан 32, бусад 705, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 1104 байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон тодорхой хөдөлмөр эрхэлдэггүй иргэд 3559, малчин 6156, оюутан 690, нийт 10405 даатгуулагч эрүүл мэндийн заавал даатгалд хамрагдсан нь нийт (16480 хүн) хамруулбал зохих иргэдийн 63.2 хувь байна. Австралийн элчин сайдын яамны санхүүжилтээр хэрэгжүүлсэн "Малчдын эрүүл мэндийг дэмжих төсөл"-ийн хүрээнд малчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж Баянхонгор, Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт, Галуут, Бууцагаан, Баянбулаг, Гурванбулаг, Жаргалант, Заг, Баянговь, Жинст, Баян-Өндөр, Шинэжинст сумдын 85 малчны 4.284.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санд төслийн нэгжээс төлж, орлого, хамрагдалтыг нэмэгдүүлсэн. Шинээр сайн дурын нийгмийн даатгалд даатгуулагчдын хувь өмнөх оноос 2.8 хувиар, эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь 5.1 хувиар тус тус өссөн байна.	100%
1	2	3	4	5	6

49		2.5.8. Коллеж төгсөгчдийг ажлын хөдөлмөр эрхлэлтийг байраар хангах замаар нэмэгдүүлж, Бизнес инкубаторын төгсөгчдийн 80%-ийг үйлчилгээг нэмэгдүүлж, байнгын болон түр хөдөлмөр эрхлэлтийг ажлын байранд нэмэгдүүлэх зуучилсан байна.	Коллеж төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг байнгын болон түр хөдөлмөр эрхлэлтийг ажлын байранд зуучилсан байна.	Политехник коллежийг 2021-2022 оны хичээлийн жилд 390 суралцагч 12 мэргэжлээр суралцаж төгссөнөөс 60 хувь нь байнгын ажлын байранд, 13.5 хувь нь түр ажлын байранд зуучлагдаж, ажилд зуучлал 73.5 хувьтай байна. Үүнээс эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж буй төгсөгч 49.8 хувь, тухайн салбарт хөрвөн ажиллаж буй төгсөгч 8 хувь, бусад салбарт мэргэжлийн бус ажил эрхэлж буй төгсөгч 42.2 хувийг тус тус эзэлж байна. Барилгын засал чимэглэлчин, Барилгын цахилгаанчин, Оёмол бүтээгдэхүүний оёдолчин, Үсчин мэргэжлүүдээр төгссөн төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь өндөр байна.	90%
50		2.5.9. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон ажиллагаа эрчимжиж тооны бус салбар төлөвлөгөө 85-аас зөвлөл болон Хөгжлийн дээш хувьтай хэрэгжиж бэрхшээлтэй хүүхдийн зорилтот бүлгийн эрүүл мэнд, боловсрол, хөгжил, оролцоо нийгмийн хамгааллын дээшилнэ. салбар комисс", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих	Салбар зөвлөл, комиссын үйл ажиллагаа эрчимжиж төлөвлөгөө 85-аас зөвлөл болон Хөгжлийн дээш хувьтай хэрэгжиж бэрхшээлтэй хүүхдийн зорилтот бүлгийн эрүүл мэнд, боловсрол, хөгжил, оролцоо нийгмийн хамгааллын дээшилнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлт 92.2 хувьтай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн төлөвлөгөөнд 23 багц ажил арга хэмжээг төлөвлөж төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай байна. Онлайн сургалтыг 4 удаа 380 хүнд, танхимын сургалтыг 46 байгууллагын 690 байгууллагад хийсэн байна. Олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд олон нийтийн сүлжээнд тавьсан хичээл болон шторкийг 16000 гаруй хүн үзсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 2022 онд 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн ажилласан төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хэрэгжсэн. Салбар зөвлөлүүд болон комиссоос зохион байгуулсан 32 удаагийн сургалт, сурталчилгаа, үйл ажиллагааны хүрээнд байгууллагуудын оролцоо 52 хувиар, иргэдийн оролцоо 5 хувиар тус тус нэмэгдсэн. Зөвлөлүүдийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтүүдийн дундаж 92.4 хувьтай байгаа нь өмнөх оноос 7.4 хувиар өссөн байна. Салбар зөвлөлүүд, комиссын үйл ажиллагаанд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.	100%
51	2.6. Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ	2.6.1. Соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, сургах	СУИС-ийн өдөр, оройн анги, богино хугацааны сургалтаар 20-оос доошгүй мэргэжилтнийг хамруулна.	Баян-овоо, Баян-өндөр, Өлзийт, Заг, Гурванбулаг сумдын соёлын төвүүдийн хөгжмийн багш соёлын төвийн эрхлэгчийг мэргэжлийн хүний нөөцөөр хангасан. "Соёлын ажилтнуудын -чадавхыг бэхжүүлэх" нь сургалтыг 2022 оны 04 дүгээр сард Гурванбулаг сумд зохион байгуулж сургалтад 320 гаруй соёлын ажилтан уран бүтээлчид хамрагдаж, Соёлын яам, СУИС"-аас зохион байгуулсан онлайн	70%
1	2	3	4	5	6

				сургалтад 19 сум, 4 мэргэжлийн урлагийн байгууллагын 130 гаруй уран бүтээлч соёлын ажилтнууд тус тус хамруулсан. МУБИС, СУИС-тай хамтран орон нутгийн "онлайн" эчнээ сургалтыг тогтмол зохион байгуулж сургалтад 8 багш хамрагдаж хөгжмийн багшийн бакалаврын зэрэгтэй төгссөн. Салбарын хүний нөөцийг чадваржуулах, орон нутагт мэргэжлийн боловсон хүчний хангалтыг тодорхой хувиар нэмэгдүүлэх зорилгоор СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежтой хамтран ажиллах хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан.	
52		2.6.2. Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадам зохион байгуулах	Монголын зохиолчдын эвлэлийг үүсгэн байгуулагч, МУ-ын төрийн соёрхолт, зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнг алдаршуулах, утга зохиолын хөгжлийг хурдасгахад дэмжлэг болно.	Төрийн шагналт яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадмыг 2022 оны 07 дугаар сарын 22-нд улсын хэмжээнд зохион байгуулж Улаанбаатар болон 5 аймгийн 40 гаруй яруу найрагчид оролцож амжилттай зохион байгуулсан. Яруу найргийн наадам жил бүр уламжлал болгон зохион байгуулагдсанаар яруу найраг сонирхогч хүүхэд, залуучуудын тоо өмнөх оноос 10 хувь өсөж, ур чадвар нэмэгдэж оролцогчдын тоо өссөн. Наадамд 3.0 сая төгрөгийн төсөв зарцуулсан.	100%
53		2.6.3. Иргэн Б.Дашгомбын бүтээсэн "Чингис хааны хөрөг"-ийг Түүх угсаатны зүй-Байгалийн музейн үзмэрт худалдан авах	Өв соёлын үнэт үзмэрийг олон нийтэд таниулан сурталчлах хүрээ өргөжнө.	Иргэн Б.Дашгомбын бүтээсэн утсан наамал бүхий "Чингис хааны хөрөг"-ийг Түүх угсаатны зүй-Байгалийн музейн үзмэрт худалдан авч үнэт үзмэрийн баяжилт хийгдсэн. Байгалийн түүхийн музейн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/01 тушаалаар уг бүтээлийг жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд тусгагдсан 18.0 сая төгрөгөөр музейн сан хөмрөгт худалдан авч сан хөмрөгийг баяжуулсан. Уг үзмэрийг музейн үзмэрт дэлгэн ард иргэдэд сурталчлан ажиллаж байна	100%
54		2.6.4. Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх, зарим нэг зүйлсийг хамгаалалтад авах	Өв соёлын үнэт үзмэрүүд хамгаалагдах аюулгүй орчин нөхцөл бүрдэнэ.	Байгалийн түүхийн музей, болон түүх угсаатны зүйн музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх, зарим нэг зүйлсийг хамгаалалтад авах ажлын хүрээнд музейн дохиолол хамгаалалтыг шинэчлэх ажлыг "Сүлжээний хөтөч" ХХК хийж гүйцэтгэсэн. Угсаатны зүйн музейд утаа мэдрэгч,хөдөлгөөн мэдрэгч, хоргоны хаалга мэдрэгч, ус мэдрэгч, дуу чимээ мэдрэгч зэрэг 5 нэр төрлийн 102 ширхэг, Байгалийн музейд 5 нэр төрлийн 58 ширхэг мэдрэгч бүхий 20.0 сая төгрөгийн дохиолол	100%
1	2	3	4	5	6

				хамгаалалтыг шинэчилснээр музейн үзмэрийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг сайжруулах нөхцөл бүрдлээ.	
55		2.6.5. Хүүхдийн Тэмүжин театрыг үзэгчдийн сандал, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	Үйлчлүүлэгчдэд соёл, үзвэрийн тав тухтай, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Хүүхдийн Тэмүжин театрыг нэн шаардлагатай 16 нэр төрлийн гэрэлтүүлэг, яригч, өсгөгч зэрэг тоног төхөөрөмжөөр хангаж төхөөрөмжийн хангалт 50% байсныг 70%-д хүргэж соёлын үйлчилгээний чанар хүртээмжид тодорхой ахиц гарч байна .	100%
56		2.6.6. Аймгийн Хөгжимт драмын театрт их засвар хийх	Театрын өнгө үзэмж сайжирч уран бүтээлчид, үйлчлүүлэгчдэд ая тухтай орчныг бүрдүүлнэ	Хөгжимт драмын театрын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилтот ажлын хүрээнд Хөгжимт драмын театрын нүүрэн талын их засварын ажлыг хийж, гэрэлтүүлгийг шинэчилж орчны тохижилтыг сайжрууллаа. Орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгийг зарцуулсан.	100%
57		2.6.7. Эрдэнэмандал хайрхны бурхны засвар, тохижилтын ажлыг хийх	Эрдэнэмандал хайрхны хөшөө, дурсгалын өнгө үзэмж сайжирна.	Баянхонгор “Тохижилт үйлчилгээ ОНӨТҮГазар” хайсыг боронзодсон, бурхны доод талын суурь, 108 шатны нурсан шаврыг нөхөн шавардаж шохойдсон, “Лхам” бурхныг тойрсон хайсанд туузан гэрэл шинээр хийж засварлах шаардлагатай гэрэлтүүлгийг засаж лампыг сольж гэрлийн шонг будаж ойр орчмын сандлуудыг янзалж будаж өнгө үзэмжийг сэргээн засварласан. Орон нутгийн төсвийн 5.0 сая төгрөгийг зарцуулсан.	100%
58		2.6.8. Бөмбөгөр сумд Гэрэлт хөшөө байгуулах	Түүх, соёл уламжлалаа сурталчилж хойч үе, олон нийтэд таниулна.	Төрийн хэмнэлтийн хуулиар санхүүжилт шийдвэрлэгдээгүй	0%
59	2.7. Хонгорын иргэн-Хонгорын баялаг	2.7.1. Залуу малчин гэр бүлд “Хамтдаа шийдье” төслийг хэрэгжүүлэх	17 сумын 3000-аас доошгүй өрхөд хүрч зөвлөн туслах, сургалт, нөлөөллийн ажил үйлчилгээг үзүүлж хүүхэд хамгааллын талаарх мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар “Хамтдаа шийдье” төсөлт арга хэмжээг мэргэжлийн удирдлага арга зүйгээр ханган НҮБ-ын хүүхдийн сан, аймгийн Засаг даргын Тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, сумдын ЗДТГ, Жаргалтай амьдрал төвтэй хамтран хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт 20 сумын 10623 өрхөд бага насны хүүхдийн цогц хөгжил, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, архидалтаас урьдчилан сэргийлэх нь зэрэг сэдвээр сургалт зохион байгуулан, эрсдэлийн үнэлгээ хийсэн. Төслийн үр дүнд: Сургуулийн өмнөх боловсролоос завсардсан 1168, сургууль завсардсан 12, өсөлт хөгжлийн	100%
1	2	3	4	5	6

				хоцрогдолтой 4 хүүхэд, архины хамааралтай 8 иргэн, гэр бүлийн хүчирхийллийн 14 кейс нийт 154 кейсийг илрүүлж, сумдын хамтарсан баг, Жаргалтай амьдрал төвд холбон зуучилсан. Сумдын хамтарсан багийн 316 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэж мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн. Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг 196 иргэнд өгч, хүүхдийн мөнгөний 19 өргөдлийг шийдвэрлэсэн. Явцын хяналт, шинжилгээ зөвлөн туслах үйл ажиллагааг Нийгмийн бодлогын хэлтсээс 2 удаа зохион байгуулсан. Шинээр 7423 өрхийг хамруулсан.	
60		2.7.2. Жендерийн салбар хороо, дэд хороодын гишүүдийг чадавхжуулах /оролцоо/	Жендерийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлж, жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг сайжруулна	Галуут, Баянлиг, Өлзийт сумдад аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн даргаар ахлуулсан баг ажиллаж, салбар хороодын ажлын хэсэг томилсон захирамж, хурлын тэмдэглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлж дүгнэсэн. Галуут сумд тус үйл ажиллагаа жигдрээгүй байсныг илрүүлж цаашид засаж сайжруулах талаар чиглэл өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа. Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд Жендерийн эрх тэгш байдал, хууль эрх зүйн хүрээнд сургалт мэдээлэл 1 удаа зохион байгуулсан. Төрийн хэмнэлтийн хууль гарсантай холбоотой зөвлөн туслах боломжгүй болсон.	100%
61		2.7.3. "Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид орчинг дэмжих нь" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх	Төслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Жендерийн салбар хороо, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, БШУГ, "Хонгор нутгийн үрс" ТББ, "Талын сарнай" ТББ-ын сургагч багш нар хамтран "БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД ОРЧНЫГ ДЭМЖИХ НЬ" төсөлт арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн. Арга хэмжээний хүрээнд Баянхонгор сумын 6 цэцэрлэгийн багш, эрхлэгч, ГБХЗХГ, Цагдаагийн газрын сэтгэл зүйч, БШУГ-ын мэргэжилтэн зэрэг 15 хүн сургагч багшаар бэлтгэгдсэн. Сургагч багш нар хүний эрх болон хүүхдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн мөн чанар, төрөл, хүүхдэд үзүүлэх хор нөлөө, уршгийн талаарх суурь ойлголтоо бататган тэлж, бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга техникт суралцан, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх ур чадвар эзэмшсэн. Сургалтын хэрэглэгдэхүүн, хэрэгцээг тодорхойлох судалгаа хийж салбар дундын хамтын ажиллагааг ханган хамтран ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Жендерийн салбар хороо, төр, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа	100%
1	2	3	4	5	6

				сайжирч орон нутгийн онцлогт тохирсон сургалтын модуль боловсруулж сургуулийн өмнөх боловсролын байгууллага, эцэг эхийн зөвлөлтэй хамтран түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.Төлөвлөгөөний биелэлт 85 хувьтай хэрэгжсэн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг түшиглэсэн салбар дундын хамтын ажиллагааны сургалтын баг бүрдэж сургалтын хөтөлбөрт жендер, хүний эрхийн чиглэлийн агуулга орсон (Төр-36 Хувь-7). 4-5 настай хүүхэд тэдний эцэг эх, багш нийт 1010 хүний мэдлэг, хандлагыг сайжруулсан.Төрийн бус байгууллагуудын олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлсэн техникийн дэмжлэгийг орон нутаг тогтвортой авч явах сайн жишиг бий болсон.	
62		2.7.4. "Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийн засаглал, хамгааллын зорилтыг хэрэгжүүлэх	Судлаач хүүхдүүдийг чадавхжуулан зорилтот 3-аас дээш бүлэгт судалгаа хийж шийдвэр гаргагчдыг мэдээллээр ханган орон нутгийн бодлого шийдвэрт хүүхдийн бодит оролцоог бий болгоно. Хүүхдийн Экспог зохион байгуулж 100-аас доошгүй хүүхдийг хамруулж алдаршуулна. "SASA" активистуудыг хөгжүүлэх, дэмжих стратегийг 80-аас дээш хувьтай хэрэгжүүлнэ	"Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийн тайланг 1, 6, 8 саруудад тайлагнасан. Засаглал, хүүхэд хамгааллын тайлангийн хуралд орон нутгийн мэдээллийг бэлтгэн цахимаар 1, танхимаар 1 нийт 2 удаа оролцож амжилттай хамгаалж хөтөлбөр дууссан. "Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийн сайн туршлагын эмхэтгэл хэвлэх асуудлыг НҮБ-ын Хүүхдийн сангийн зөвлөх, орон нутгийн удирдлагын багт уламжилж, 2650000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн, эмхэтгэлийг боловсруулж, 500 ширхгийг хэвлэн сум, байгууллагуудад түгээсэн. Хөтөлбөрийн удирдлага болон хэрэгжүүлэгч багуудын уулзалтыг улирал тутам зохион байгуулж мэдээ мэдээллийг солилцон цаг үеийн ажлыг шуурхай шийдвэрлэн ажилласан.	90%
63		2.7.5. Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийг тоног төхөөрөмжөөр хангах	Орон нутгийн эмэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн төслийг хэрэгжүүлнэ.	Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 505.308.233 төгрөгийн өртөгтэй цахим сургалтын 21 төрлийн тоног төхөөрөмжөөр хөдөөгийн 19 сум, Баянхонгор сумын 2 нийт 21 танхимыг тохижуулж, сум бүрд иргэдэд цахимаар сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах орчин	100%
1	2	3	4	5	6

				бүрдсэн.	
64		2.7.6. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийслэлд нийтийн тээврээр үнэгүй зорчсон нөхөн олговор	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийслэлд нийтийн тээврээр үнэгүй зорчсон нөхөн олговрыг олгосон байна.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр 2022 онд үнэ төлбөргүй зорчсоны төлбөр 10.0 төгрөгийг холбогдох тоон мэдээлэл, гүйцэтгэлд үндэслэн нийслэлийн Нийтийн тээврийн газарт олгож, журмын хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%
65		2.7.7. Угийн бичиг хөтлөх танхим байгуулах	Угийн бичиг хөтлөх танхим байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ.	Төрийн архивын уншлагын танхимын үйл ажиллагааг өргөтгөн, Ураг удам угсаа судлах танхимыг Төрийн архив дээр байгуулж нээлтийг 10 дугаар сарын 31-нд хийлээ. Дээрх танхимын үйл ажиллагааг өргөтгөснөөр Үндэсний төв архиваас судалдаг хүн амын лавлагааг орон нутагтаа онлайнаар үзэх, ураг удмын түүхээ бичих боломж бүрдэж байгаа юм. Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөлт 10.3 хувьтай байна.	100%
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО					
66	3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна.	3.1.1. Татварын хууль эрх зүйн актуудын шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх болон цахимаар татвар, төлбөр, хураамжаа төлөх хандлагыг төлөвшүүлэх, татварын бааз суурийн бүртгэл мэдээллийг сайжруулах замаар төсвийн орлогыг 2021 оны суурь төвшнөөс 45%-иар нэмэгдүүлэх	Аймгийн Татварын болон татварын бус орлогын хэмжээг 16.3 тэрбум төгрөгөөс давуулан биелүүлэх	2022 онд улс, орон нутгийн төсөвт нийт 19.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс өссөн дүнгээр улсын төсөвт 2.8 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 2.9 тэрбум төгрөг төвлөрүүлж 106.3 хувийн биелэлттэй буюу 175.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Орон нутгийн төсвийн татварын орлогоор 17.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 21.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, 126.7 хувийн биелэлттэй буюу 4.6 тэрбум төгрөгөөр давуулан биелүүллээ. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогоор 2022 оны өссөн дүнгээр нийт 20.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 24.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, 123.9 хувийн биелэлттэй буюу 4.8 тэрбум төгрөгөөр татварын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж, аймгийн Хөгжлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаад байна. Татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс хамтран 2022 онд аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгавар, “Тээврийн хэрэгслийн бүртгэл, татвар хураалтын ажлыг эрчимжүүлэх тухай” А/660 тоот захирамжийг гаргуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг төрийн бусад байгууллагуудтай хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. НӨАТ-ын	100%
1	2	3	4	5	6

				хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төлөвлөгөө гаргаж, зах, худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулдаг цахим төлбөрийн баримт олгодоггүй бизнес эрхлэгч, цахим худалдаагаар бараа, бүтээгдэхүүн борлуулагч этгээдийг бүртгэлжүүлэн, цахим төлбөрийн баримт олгуулж, хэвшүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.	
67		3.1.2. Санхүүгийн эрсдэл бүхий 2 байгууллагад дотоод аудит, 2 суманд Аймгийн Засаг даргын нэрэмжит зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	Төсөвт байгууллагын санхүүгийн эрсдэлийг бууруулж 23%-д хүргэж, төсвийн үр ашгийг дээшлүүлнэ.	Засаг даргын 2022 оны А/221 дүгээр захирамжаар Баян-Овоо, Бууцагаан, Шинэжинст, Баян-Өндөр сумдын төсөвт байгууллагуудын 2020, 2021 санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит, санхүүгийн үзлэгийг хийж гүйцэтгэлээ. Санхүүгийн үзлэгийн үр дүнгээр Баян-Овоо сумд 170.474.700 төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч Улсын ахлах байцаагчийн 2.952.500 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3.931.100 төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 163.591.100 төгрөгийн зөвлөмж, Бууцагаан сумд нийт 271.531.650 төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч Улсын ахлах байцаагчийн 12.260.253 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 62.457.071 төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 196.814.326 төгрөгийн зөвлөмж, Шинэжинст сумд нийт 99.584.525 төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч Улсын ахлах байцаагчийн 14.336.798 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2.000.000 төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 83.247.727 төгрөгийн зөвлөмж, Баян-Өндөр сумд нийт 44,560,809 төгрөгийн санхүүгийн зөрчил илэрч Улсын ахлах байцаагчийн 1.513.550 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 43.047.259 төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлж ажилласан. Баян-Овоо сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 28.8 хувь, Бууцагаан сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 32.2 хувь, Шинэжинст бууруулж сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 21.4 хувь, Баян-Өндөр сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 16.2 хувиар тус тус бууруулсан байна. Нийт эрсдэлийн түвшинг бууруулж 23.1 хувьд хүргэж, төсвийн үр ашгийг дээшлүүлсэн. Эрдэнэцогт сумын 6 төсөвт байгууллагуудын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөн туслах чиглэлээр дэмжлэг үзүүлж байгууллагын “Үнэ цэнийг нэмэгдүүлэх-Эрсдэлгүй объект зөрчилгүй хамт олон” болгох зорилтыг хангаж ажилласан.	100%
1	2	3	4	5	6

68		3.1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллого явуулах	Төрийн болон орон нутгийн өмчит хөрөнгийн ашиглалт, хамгаалалт сайжирсан байна.	Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчит байгууллагуудын эд хөрөнгөд үзлэг тооллогын ажлыг чанартай зохион байгуулж ТӨБЗГазарт хугацаанд нь нэгтгүүлж дууссан байна. Дээрх тооллогын ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын А/247 дугаар захирамжаар тооллогын комисс байгуулагдан орон нутгийн өмчит байгууллагуудын газар, барилга, тээврийн хэрэгсэлтэй нэг бүрчлэн танилцаж арга зүйн зөвлөгөөгөөр ханган зөрчилтэй хуулийн этгээдийн мэдээлэл, газар, тээврийн хэрэгслийн мэдээллийг гаргаж зөрчлийг арилгуулан ажиллаж байна. Тооллогын ажлын хүрээнд 173 байгууллагын 740 ширхэг 10,8 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгсэл хамрагдсанаас 650 тээврийн хэрэгсэл зөрчилгүй, 25 тээврийн хэрэгсэл улсын дугаар шинээр авах, акталж, дуудлагын худалдаагаар хувьчилсан 65 тээврийн хэрэгслийг авто тээврийн нэгдсэн сангаас хасалт хийлгэх шаардлагатай байна. Газрын нэгдсэн мэдээллийн санд орон нутгийн өмчит байгууллагуудад бүртгэлтэй нийт 696 нэгж талбарын 5,4 сая мкв газрын мэдээлэл хамрагдсанаас Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор газрыг үнэлж аваагүй 130 байгууллагын 358 нэгж талбарын 1.6 сая мкв талбайг балансад бүртгэлжүүлэх, суурь үнэлгээ зөрүүтэй 64 байгууллагын 117 нэгж талбарын зөрчил гарсныг арилган ажилласан.	100%
69		3.1.4. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, төрийн мөнгөний бодлогын талаар гарсан шийдвэрүүд, түүний хэрэгжилтийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр мэдээлэх, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр	Аймгийн төвийн болон хөдөө сумдын 500 иргэнд санхүүгийн мэдлэг олгосон байна.	“Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцгаая” нэртэй аяныг зарлаад Хадгаламжийн даатгалын корпорацтай хамтран хэрэгжүүлж ЕБС-ийн 1-5 ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, 6-12-р анги болон Политехникийн коллеж, Өлзийт МСҮТ-ийн сурагчдын дунд постерын уралдаан зарлаж 2022 оны 10 дугаар сард дүгнэн шагнал урамшууллыг олголоо. Баянхонгор сумын Тамгын газар, багийн идэвхтэн нийгмийн ажилтнуудтай хамтран сумын 1200 орчим хүнд санхүүгийн боловсролын сургалтыг хийж ажилласан. Тайлант хугацаанд сошиал орчинд давхардсан тоогоор 215 мэдээ, мэдээлэл түгээж 41241 иргэн үзэж сонирхон лайк, шейр хийсэн байна. Мөн "Дэлхийн мөнгөний долоо хоног -2022" аяны хүрээнд Насан туршийн боловсролын төв, Баянхонгор аймаг дахь Монгол банк, Хадгаламжийн Даатгалын Корпорац, хамтран аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах, дунд ангийн 620 орчим	100%
1	2	3	4	5	6

		сургалт сурталчилгаа хийх		сурагчдын дунд цахим сургалт зохион байгууллаа. “Жижиг мөнгөн тэмдэгтийг хэн сайн цуглуулах вэ” уралдааныг 2022 оны 04 дүгээр сарын 25-аас 2022 оны 5 дугаар 25-ны өдрийг дуустал 1 сарын хугацаанд зарласан нийт Баянхонгор аймаг болон 19 сумдаас 60 орчим хүүхэд багачууд цуглуулсан жижиг дэвсгэртээ тушааж нийтдээ 63,000 орчим ширхэг жижиг мөнгөн дэвсгэртийг банкнуудад тушааж оролцсон байна. "Дэлхийн мөнгөний 7 хоног 2022" аяны хүрээнд банкнууд болон Насан туршийн боловсрол, ХДК-тай хамтран Постер, Гар зураг, Эсээ бичлэгийн уралдааныг аймгийн хэмжээнд сурагчдын дунд амжилттай зохион байгуулж, тэмцээний шагналд ХДК-ийн зүгээс гарын бэлэг, 200.000-50.000 төгрөгөөр хадгаламж нээлгэх эрхийн бичгээр урамшуулж иргэдийн хадгаламж, хуримтлалыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж ажилласан.	
70		3.1.5. “Бид ирээдүйн татвар төлөгч” арга хэмжээг Баянхонгор аймгийн ЕБС-ийн хүүхэд багачуудын дунд зохион байгуулах	ЕБС-ийн 10 сургуулийн сурагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлж татварын үнэ цэнийг таниулна.	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад татварын талаар ойлголт мэдлэг өгөх зорилгоор аймгийн төвийн 5 сургуулийн 400 гаруй сурагч, 19 сумын 19 ерөнхий боловсролын сургуулиудад Татварын хэлтсээс бэлтгэсэн "Татвар гэж юу вэ", "Татвар бидний амьдралд" хичээлийг татварын улсын байцаагч нар хүүхдүүдэд танилцуулж, мэдээллийг хүргэлээ. Баянхонгор аймгийн Татварын хэлтэс facebook группт "Татвар бидний амьдралд" ЕБС-ийн сурагчдад зориулсан 4 хичээлийн контент байршуулж, олон нийтэд сурталчлан ажилласан. ЕБС-ийн сурагчдын дунд "Миний мэдэх татвар" гар зургийн уралдаан, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Баянхонгор дахь салбартай хамтран "ОЙН НАЙЗУУД БА ТАТВАР"-богино хэмжээний контент бэлтгэх уралдааныг зохион байгууллаа. ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулсан уралдаан тэмцээнд амжилттай оролцсон хүүхэд багачуудад Өргөмжлөл, мөнгөн шагнал олголоо. Тэмцээн уралдаанд оролцсон бүх хүүхдүүдэд Талархал гардуулж, өнгийн харандаа болон "ТАЗИ зөгийн адал явдал" татварын талаар ойлголт мэдээлэл өгөх номыг гардууллаа. 2022 оны 9, 10 дугаар сард аймгийн төвийн болон сумдын ЕБС-ийн сурагчдад татварын талаарх ойлголт мэдлэг олгох 10 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.	100%
71		3.1.6. Сумдын Санхүүгийн албаны 20	Төрийн сангийн нэгжүүдийн төлбөр	Баянхонгор аймгийн төсөвт байгууллагуудын төрийн сангаар хийгдэх төлбөр тооцоог 2023 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн	100%
1	2	3	4	5	6

		нэгж, аймгийн төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах, нэгжүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	тооцоо, төлбөрийн баримтын архив 100 хувь цахим тогтолцоонд шилжиж, компьютер техник хэрэгслийг бүрэн шинэчилсэн байна.	100 хувь цахим буюу ПОРТАЛ системээр дамжуулан хийхээр төлөвлөсөн, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 20 сумын санхүүгийн албанд 20 ширхэг Dell брэндийн Компьютер, 20 ширхэг архивын нягтруулсан шүүгээг нийлүүлэх ажлыг АЙ ТИ ЮНИПИКЕЙШН ХХК-тай 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 2022/50 дугаартай гэрээ байгуулж, 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр хүлээн авч, сумдын санхүүгийн албадад гардуулан өгсөн.	
72	3.2. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээг дэхүүн	3.2.1. Хүн амын хүнсний хэрэгцээний махны нөөцийг бүрдүүлэх	Хүн амын хаврын улирлын махны нөөцийг 200,0 тн-оор бүрдүүлж, хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулж үнийн хөөргөдлөөс сэргийлнэ.	Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ийн Мах март махны үйлдвэртэй 160тн, "Баянжаргант хүнс" ХХК-тай 40тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуйн нэгжүүд Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэнгээр, зоориноос гулуузаар хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжийн дагуу хийсэн. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8000, үхэр /1кг/ 10000 төгрөгөөр тус тус худалдаалан, үнийн хөөргөдөл үүсгэхгүй нөхцөлийг ханган ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2022 оны 04 дүгээр сарын 10-аас 06 дугаар сарын сарын 10 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилтийг "Баянхонгор констракшн" ХХК, "Баянжаргант хүнс" ХХК-д 100.0 сая төгрөгийг олгосон..	100%
73		3.2.2. Аймгийн мэргэжлийн холбоодуудын үйл ажиллагааг дэмжих /Оёдолчид, тогоочид, үсчид, гуталчид, бусад/	Мэргэжлийн холбоо 2-ыг шинээр байгуулж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулсан байна.	Баянхонгор аймгийн Гар урчуудын холбоо, Гуталчдын холбоо шинээр байгуулагдсан. Мэргэжлийн холбоодыг чадавхжуулах, үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд гуталчдын холбоо, хүнсчидийн холбоодын 40 гаруй төлөөлөл 2022 оны 04 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд гутал үйлдвэрлэлийн түүхий эд арьс шир боловсруулах, арьс, ширний лаборатори, гутлын түүхий эд материалын үйлдвэр "Мон ирээдүй ХХК", "Лугати ХХК", "Дархан минж ХХК", гутлын хими цэвэрлэгээний "Си Эс Эл ХХК" /Shoes love/-тай, хүнсний "Траст трейд ХХК", гялгар уут, сав баглаа боодлын "Об пластик ХХК", хүнсний салбарын тэргүүлэх мэргэжилтэн бэлтгэдэг "Технологийн дээд сургууль"-аар тус тус зочлон туршлага судлуулав. Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад ажиллаж буй	100%
1	2	3	4	5	6

				мэргэжлийн тогооч нарын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, орон нутгийн онцлогтой брэнд хоол, ундааг шалгаруулах, харилцан туршлага солилцох үүднээс 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “АЙМГИЙН АВАРГА ТОГООЧ-2022” шалгаруулах уралдааныг зохион байгуулж, салбарын нийт 45 гаруй тогооч, оюутан нар өрсөлдсөн. Түүнчлэн Баянхонгор аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойд зориулж урчууд, уран бүтээлчдийг дэмжих, аймаг орон нутгийнхаа онцлог шинж чанарыг харуулсан, гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээнд нийцэхүйц загвар дизайн, сав баглаа боодолтой бэлэг дурсгал, гар урлалын брэнд бүтээгдэхүүнийг бий болгох зорилгоор “БАЯНХОНГОРЫН ОНЦЛОГТОЙ ГАР УРЛАЛЫН ХӨГЖИЛ” анхдугаар зөвлөгөөнийг 05 дугаар сарын 01-нд Гар урчуудын холбоотой хамтран зохион байгуулж 10 гар урчдад нийт 50.0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн зүгээс олгохоор төсөл зарласан. Төв, хангайн бүсийн үсчин, гоо засалчдын уралдааныг аймгийн үсчдийн холбоотой хамтран 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Тус уралдаанд төв, хангайн бүсийн 100 гаруй үсчид 2 өдрийн турш ур чадвар, мэргэжлээрээ өрсөлдөн шилдгүүдээ шалгаруулсан. Мэргэжлийн холбоотой хамтран ажилласнаар тэдний саналыг бодлого төлөвлөлт, бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх боломж бүрдэж байна.	
74		3.2.3. Ингэний сүүний үйлдвэр, Мах, ногооны зоорь, Ногоон шим төслийг хэрэгжүүлэх	Ингэний сүүний үйлдвэр, Мах, ногооны зоорь, Ногоон шим төслийн үйл ажиллагааг эхлүүлнэ.	Хөдөө аж ахуйн кластер байгуулах ажлыг 2021 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2024 онд хэрэгжүүлэн дуусахаар төслүүд хэрэгжиж байна. Ингэний сүүний үйлдвэрийн төслийн ажилд 4 барилгын ажил болон үйлдвэрийн барилгын тоног төхөөрөмжийн ажлууд багтсан бөгөөд эхний барилга болох Ингэний сүүний үйлдвэрийн үндсэн барилга 100 хувь баригдаж хүлээлгэн өгсөн. Барилгын ажлын гүйцэтгэгчээр "Базардарь"ХХК ажилласан. Ингэний сүүний үйлдвэрт 2021-2022 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Мах, ногооны 1000тн-ийн зоорийн барилгын ажил нь 40 хувьтай ба 2023 онд дуусгах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна. Мах ногооны зоорь барих ажлын гүйцэтгэгчээр "Сант Өндөр" ХХК ажиллаж байна. Тус ажлын нийт санхүүжилт 3.1 тэрбум бөгөөд 2021-2022 онд 1.2 тэрбум төгрөг олгосон. Мах, ногооны 1000 тн-ийн зоорины барилгын ажил	70%
1	2	3	4	5	6

				нь 40 хувьтай ба 2023 онд дуусгах төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна. Мах ногооны зоорь барих ажлын гүйцэтгэгчээр "Сант Өндөр" ХХК ажиллаж байна. Тус ажлын нийт санхүүжилт 3.1 тэрбум бөгөөд 2021-2022 онд 1.2 тэрбум төгрөг олгосон. Хөдөө аж ахуйн кластер төсөл 2024 онд бүрэн хэрэгжиж эхлэх бөгөөд экспортод бараа бүтээгдэхүүнээ борлуулж, малчдын амьжиргааг хоршоолуулан дэмжиж, 2000 гаруй ажлын байр бий болох юм.	
75		3.2.4. Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээл дэд төслийн ажлыг эхлүүлэх	Баялаг бүтээгч-Баянхонгор хөтөлбөрийн хүрээнд газар тариалан, Хөдөө аж ахуйн кластерыг хэрэгжүүлэх	Баян-Өсөх-Агро" ОНӨҮГ-ын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу энэ онд 480.0 сая төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн. 1-р багц: Хөдөө аж ахуйн кластерын барилга байгууламж, 500 тн-ын багтаамж бүхий зоорь агуулахын хундамын цутгалт хийгдсэн. 2-р багц: Баянлиг, Бууцагаан, Хүрээмарал сумдад гүн өрмийн худаг гаргах, Баацагаан, Баянцагаан, Жинст, Бууцагаан, Хүрээмарал, Жаргалант, Баянлиг зэрэг 7 суманд тус бүр 50 га нийт 350 га талбайг хашиж хамгаалах ажлаас Хүрээмарал сумд гүн өрмийн худаг гаргаж, Бууцагаан сумын 40 га талбайг хашаажуулсан. 3-р багц: Өлзийт сумын нутаг дэвсгэрт КТП-6 дэд станцыг суурилуулж, тог татсан. 4-р багц: Газар тариаланд ашиглах Трактор, тоног төхөөрөмж худалдан авахаар гэрээ байгуулагдсан. 5. Хөдөө аж ахуйн кластерын барилгын гадна тохижилт, хүрмэн бетон хашааны ажлаас 4 га-д 4 тал блокон хашаа баригдаж эхэлсэн, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан ирэх хавар ажлыг дуусгахаар материалаа бүрэн татсан. Дээрх төсөл хэрэгжсэнээр малын тэжээлийн үйлдвэр байгуулагдана.	90%
76		3.2.5. Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийг хэрэгжүүлэх	Шинэ хөдөө төслийг эхлүүлсэн байна.	Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл нийт төсөвт өртөг 2.5 тэрбум төгрөг бөгөөд 2022-2023 онд хэрэгжихээр ХХААХҮЯ-ын захиалгаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт нийт 3 багц ажил, арга хэмжээний тендер зарлагдсан байна. 2022 онд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр багц 1 буюу Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийн зориулалттай тусгай үйлчилгээний автомашины худалдан авах тендер зарлагдаж, гүйцэтгэгчээр "Улаанбаатар ариутгал" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан. Нийт 15 тусгай зориулалтын машин нийлүүлэгдэхээс 2 машин нийлүүлэгдэж үлдэгдэл 13 нь 2023 оны 1 дүгээр улиралд ирнэ. 2023 онд багц-2 Хүнсний ногооны хүлэмж	90%
1	2	3	4	5	6

				трактор, иж бүрдэл 1.210 сая төгрөг, багц-3 Малын зохиомол хээлтүүлгийн зөөврийн пункт, багажны иж бүрдэл, ачааны машин 290.0 сая төгрөг нийт 1.5 тэрбум төгрөгийн санхүүжилттэй ажил арга хэмжээ хүлээгдэж байна.	
77		3.2.6. Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж		Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх сонгон шалгаруулалтад "Батбилэг Гурван Эрдэнэ" ХХК шалгарч гэрээ байгуулан техникийн тодорхойлолтод тусгагдсан 11 төрлийн тоног төхөөрөмжийг Баянхонгор, Баянлиг, Баацагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан, Заг сумдад бүрэн нийлүүлж улсын төсвөөс 450.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	100%
78		3.2.7. Үзэсгэлэн худалдаа гаргах зориулалтын /асар/ талбай байгуулж, Жижиг дунд үйлдвэрлэл, Мал аж ахуй, Газар тариалан эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах сувгийг нээж, орлого нэмэгдүүлэх.	20-оос дээш иргэн, аж ахуй нэгж оролцох багтаамжтай 4-н улирлын талбайд байршуулах 20 асар майхан худалдан авч, жилд 2-оос доошгүй үзэсгэлэн худалдааг зохион байгуулж Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэнээр орлого нэмэгдсэн байна.	Үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ая тухтай үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болгож 20 асар майхан худалдан авсан. Орон нутагт аймгийн түүхт 80 жилийн ойн хүрээнд "Баянхонгорт үйлдвэрлэв", "Намрын ногоон өдрүүд", "Говийн чоно" олон улсын сургалт, дадлагын үеэр нийт 3 удаагийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж давхардсан тоогоор 180 гаруй иргэн, ААН оролцож 80 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилсан байна. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "Намрын ногоон өдрүүд" "Нүүдэлчин Монгол" фестивалийн үзэсгэлэн худалдаанд 10 иргэн, ААН бүтээгдэхүүнээ сурталчлан оролцсон.	100%
79	3.3. Эрүүл хөрс-Эрүүл хүнс	3.3.1. Хөдөө аж ахуйн салбарт нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэх	Сумдын Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулан салбарын боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх эхлэлийг тавьж хэрэгжүүлнэ. /21 хүн/	Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг хангах зорилгоор Хөдөө, аж ахуйн их сургууль, Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга, суралцагч нар хамтарсан гэрээ байгуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр оюутны сургалтын төлбөрийн 50 хувийг дааж дэмжлэг үзүүлсэн. 2021-2022 оны хичээлийн жилд агрономич 1, малын их эмч 2, мал зүйч буюу зоотехникчээр 16 оюутан нийт 19 оюутан суралцахаар гэрээ байгуулан сургалтын төлбөрт 27.2 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлэсэн. Суралцагчдаас 1 оюутан төгсөж Баянбулаг сумын Хөдөө аж ахуйн тасагт ажиллаж байна.	100%
		3.3.2. Бэлчээрийн усан	Гүн өрмийн 4 худаг	Улсын төсвийн хөрөнгөөр Өлзийт сумд 1, аймгийн орон нутгийн	
1	2	3	4	5	6

80		хангамжийг нэмэгдүүлж, уст цэгийн хайгуул хийх	шинээр гаргах буюу сэргээн засварлан, 20 цэгт уст цэгийн хайгуул хийж 30 мянган га талбайг усжуулж бэлчээр ашиглалтыг сайжруулна.	хөгжлийн сангийн санхүүжилтээр Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр, Жинст, Эрдэнэцогт сумдад нийт 5, гадаадын төсөл хөтөлбөрөөр Шинэжинст сумд 3, Баацагаан, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Баянцагаан, Бөмбөгөр сумдууд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19, Бөмбөгөр, Гурванбулаг, Хүрээмарал, Шинэжинст сумдын малчид өөрсдийн санаачилга, хөрөнгөөр 6 худаг нийт 34 худаг шинээр гаргаж, засварласан нь 34.0 мянган га талбай бэлчээрийг усжуулж, 68.0 мянган толгой мал, амьтан усаар хангагдлаа. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр уст цэгийн хайгуулыг Баян-Өндөр, Шинэжинст сумдууд 17 цэгт хийсэн.	100%
81		3.3.3. Сарлаг болон бог малын хээлтүүлэгчдэд үзлэг, ангилалт хийх /Баянцагаан болон бусад сум/	20 сумын 13818 бог малын хээлтүүлэгчийг үзлэг, ангилалтад хамруулж цөм сүргийн тоог нэмэгдүүлнэ.	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад байлгах зорилгоор 20 сумын бог малын 10.6 мянган хээлтүүлэгчийг 86 суурьт ялган төвлөрүүлсэн. Бог малын хээлтүүлэгчийг хавар намрын үзлэг ангилалтад 20 сумын 14.1 мянган малыг хамруулсан. Ангилалтаар амьдын жингийн үзүүлэлт аймгийн дунджаар өсвөр хуц 33 кг, бүдүүн хуц 55 кг, өсвөр ухна 22 кг, бүдүүн ухна 41 кг амьдын жинтэй байгаа нь тухайн төрлийн малын амьдын жингийн стандартыг хангаж байна. Эрдэнэцогт сум ОНХС-ын хөрөнгөөр 648 сарлагт үзлэг ангилалт хийсэн. Үүний үр дүнд ашиг шимийн үзүүлэлт хангаагүй 46 толгой малыг заазлав. Баталгаажсан үүлдэр омгийн цөм сүргийн малын тоо 86.8 мянган толгой байна.	100%
82		3.3.4. Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж, нэгдсэн зохион байгуулалттайгаар хүлэмж нийлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Тариалан бүхий сумдад шинээр 1 хүлэмжийн аж ахуйг бий болгон 4*8 хэмжээтэй 25 хүлэмж авч тариаланчдад олгон хамгаалагдсан хөрсний тариалалтыг 30 хувиар өсгөнө.	Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариалангийн бүс нутгийг тогтоох, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, голлох нэр төрлийн хүнсний ногоо, чацаргана, жимс жимсгэний нутагших чадвартай үр, сортыг бодлогоор хөгжүүлж дотоодын болон бүсийн хэрэгцээг хангах зорилгоор Баян-Овоо сумын “Даян дуулим” ХХК-тай хамтран ажиллаж 23.0 мянган чацарганын суулгацыг нэмж тариалах ажлыг хэрэгжүүлсэн. Тус ХХК нь ЖДҮ-ийг дэмжих зээлд хамрагдаж үйл ажиллагаагаа өргөжүүлж байна. Хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлж, өрхийн тариалангийн үйл ажиллагааг өргөжүүлэн хүн амын хүнсний хангамжийг өсгөх зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газар нь “Алтан сапа” ХХК-тай гэрээ байгуулан хүлэмжийн худалдааг аймгийн төвд 2 өдрийн хугацаанд зохион байгуулсан. Баянхонгор	90%
1	2	3	4	5	6

				сум 3*4 хэмжээтэй 6 ширхэг 72 м2, 4*6 хэмжээтэй 7 ширхэг 168 м2, 4*8 хэмжээтэй 8 ширхэг 256 м2, Баян-Өндөр сум 1 ширхэг 120 м2, Хүрээмарал 1 ширхэг 12 м2, Жаргалант 3 ширхэг 96 м2, Баянцагаан 1 ширхэг 12 м2 нийт 27 ширхэг 736 м2 бүхий 37,5 сая төгрөгийн хүлэмжийг иргэд өөрсдийн хөрөнгөөр худалдан авсан ба компанийн зүгээс урамшуулал болгож 3,5 сая төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг услалтын системийг үнэ төлбөргүйгээр иргэдэд олгосон. Хамгаалагдсан хөрсний тариалалт, хураан авсан ургацын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 3 хувиар нэмэгдэж 98 тн ургац хураан авсан. Хүнс амын хүнсний ногооны 11.2 хувь, төмсний 53.6 хувийг хангаж байна.	
83		3.3.5. Малын ашиг шим хэмжих багаж тоног төхөөрөмж авах	Хүнс Хөдөө аж ахуйн газар, 20 сумын Хөдөө аж ахуйн тасгийг нийт 22 ширхэг малын үржлийн ажлын багаж, тоног төхөөрөмжөөр хангана.	Малын амьдын жин тодорхойлох багаж буюу 500 кг хүртэл хэмжих 22 жин, 1000 кг хүртэл хэмжих 1 жин нийлүүлэх ажилд “Тэгш бүрэн заяа” ХХК шалгарч гэрээ байгуулан гүйцэтгэсэн. Тус гэрээний дагуу нийт 2 төрлийн 23 ширхэг мал жигнэх жин хүлээн авч аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар болон 20 сумын Хөдөө аж ахуйн тасагт хүлээлгэн өгч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үржлийн малд үзлэг ангилалт хийн, ашиг шимийн үндсэн үзүүлэлтийг тогтоох зорилготой малын галбир, бие цогцсын үндсэн хэмжилт хийх зориулалттай гурван төрлийн зоо-багажийг 20 сумын хөдөө аж ахуйн тасагт олгосон. Үүнд туушин метр, мал жинлэгч жин, таяган метр зэрэг юм.	100%
84		3.3.6. Үржлийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор хээлтэгч мал худалдан авах	100 толгой хээлтэгч мал худалдан авна.	Сүргийн бүтцэд хонин сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацыг сайжруулах, сүргийн чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Увс аймгийн Баяд үүлдрийн хонийг цэврээр нь үржүүлэх Цөм сүргийн нэгжийг Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газрын харьяанд байгуулж Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авч сүргийн бүтцийг сайжруулсан.	100%
85		3.3.7. Цөм сүргийн малын хашаа барих	500-600 бог малын багтаамжтай иж бүрэн малын хашаа барина.	Баянцагаан сумд бойжуулж буй Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонийг бойжуулах сүргийн бэлчээрийн онцлогт тохирсон, бэлчээрийн даац сайтай өвөлжөө буюу 500-600 бог малын багтаамжтай иж бүрэн малын хашааг "Цагаан голын ам" газарт барьж ашиглаж байна.	100%
		3.3.8. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	Аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс	Монгол Улсын Засгийн газрын 277 дугаар тогтоолоор аймаг, сумын аюулгүйн нөөцөд 1200 тн өвс, 700 тн тэжээл бэлтгэхээс 1063.1 тн	
1	2	3	4	5	6

86			тэжээл бэлтгэнэ.	өвс, 401.9 тн тэжээл бэлтгэсэн. Малчдын түвшинд бэлтгэх шаардлагатай өвс тэжээлийн 31.5 хувь, аймгийн аюулгүй нөөцийг 80.3 хувь, сумын аюулгүй нөөцийг 71.7 хувийг тус тус хангасан. Аймгийн Онцгой Комиссын 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4/19 хурлын шийдвэрийн дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 41.7 тн улаан хивэг нэмж бэлтгэсэн.	100%
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
87	4.1. Эх байгаль-Ногоон байгууламж	4.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд жилд шат дараатайгаар 500.000 доошгүй тарьц суулгацыг үржүүлж ногоон байгууламжид гаргана. Мөн Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрыг өргөтгөж тарьц суулгацыг нэмэгдүүлж ажиллана	Аймгийн хэмжээнд 500.000 тарьц суулгацыг тарьж амьдралтын хувийг 80-иас дээш хувьд хүргэж, хайс хамгаалалт, арчилгаа усалгааны асуудлыг шийдвэрлэсэн байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц суулгацыг нийлүүлэх зорилгоор Улсын төсвийн 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Сум дундын Ойн ангийн Мод үржүүлгийн газрын талбайг 10 га болгон өргөтгөн хашаажуулж, ногоон байгууламжийн усалгаанд шаардлагатай 2 худгийг гарган, 6*20 хэмжээтэй 10 ширхэг зуны хүлэмж, зоорь, 8*6 хэмжээтэй мод тарьц, суулгац худалдаалах байрыг шинээр барьсан. Мөн 3 төрлийн 55.000 ширхэг /Сухай, Улиас, Бургас/ мөчрийн тайраадас, 10 төрлийн 2000 ширхэг тарьц, суулгац, 12 төрлийн 606 кг /бохир жингээр/ үрийн нөөцөөр хангаж, ногоон байгууламжийн арчилгаанд шаардлагатай 12 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдээр хангагдан ажиллаж байна. Энэ онд 115.000 ширхэг улиас, 123.000 ширхэг бургас, 12.000 ширхэг сухай нийт 3 төрлийн 250 мянган ширхэг харандаан суулгацыг бойжуулах талбайд 200 ширхэг дэвсгэг бэлтгэж, тариалалт хийж бүрэн дууссан. Эх ургамлын талбайд 1000 ширхэг мод бутыг тариалж, 8 төрлийн 167 кг үрийг 2 хүлэмж болон бойжуулах талбайд тарилт хийгдсэн. Бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрөөр нийт 6414 иргэн, 537 аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага оролцож нийт 211924 ширхэг мод тарьж усалгаа арчилгааг хийсэн амьдралт 70.8 хувьтай байна. Энэ нь урьд оны мөн үеийнхтэй харьцуулбал 4 дахин их ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.	90%
88		4.1.2. Түйн голын сав дагуу ойн зурвас бий болгож мод үржүүлгийн талбай байгуулах	Мод үржүүлгийн талбайг хариуцан хамгаалж, арчилж ургуулах үйл ажиллагааны зардал болон талбайг 3га	Түйн гол дагуух ойн зурвасын 2.7 га талбайд ногоон ажлын байр хөтөлбөрт хамрагдсан 50 иргэн 1552 ширхэг мод тарьж, арчилгаа, усалгаа тогтмол хийж гүйцэтгэсэн. Өлзийт сумын 6 дугаар багийн нутагт 2 га талбайд мод үржүүлгийн талбай байгуулах ажлын гүйцэтгэгч "Даян дуулим" ХХК-тай 2022 оны 10 дугаар сард гэрээ	90%
1	2	3	4	5	6

			газраас доошгүй нэмэгдүүлж хайс хашлагыг сунган, 2300 ширхэг тарьц суулгацыг тарьж амьдралтыг 80 хувиас дээш хүргэсэн байна.	байгуулсан. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж хашаа хамгаалалт, шаардлагатай услалтын систем, бараа материалын татан авалтыг хийсэн бөгөөд гэрээний дагуу 2023 оны хавар тус ажлыг хийж дуусгана. Мөн Өлзийт сум 6-р багийн нутагт 2 га талбайд 4800 ширхэг хайлаасыг тарьж ургалтын хувийг 70 хувьд хүргэсэн.	
89		4.1.3. Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах	Аймгийн төвийн болон төв суурин газруудын ногоон бүсд таригдах тарьц суулгацыг бэлтгэх агро үржүүлгийн төв байгуулна	Шинэ суурьшлын бүсийн 2 га талбайд 600 м хашаа, 8*10 хэмжээтэй байшин, усалгааны систем бүхий аймгийн төв болон төвийн бүсийг тарьц суулгацаар хангах шинэ мод үржүүлгийн газрыг байгуулсан.Тус мод үржүүлгийн газарт энэ онд хайлаасны 5 кг үр, 5 төрлийн 1600 ширхэг эх мод, 50.000 ш бургас, улиас, уд модны тайраадас суулгасан. Шинээр тарьсан модны амьдралтын хувь 90 хувьтай байсан боловч хашаа хамгаалалт муу байсны улмаас мэрэгч амьтад ургаж буй модны шинэ залуу найлзуур болон үрээр тарьсан тарьцыг ихээр идэж гэмтээн амьдралтын хувь 75 хувь хүртэл буурсан байна.	100%
90		4.1.4. Говийн бүсийн сумдыг модны тарьц суулгацаар хангах Богд сумын Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг сайжруулах	Үр, тарьц суулгац үржүүлэх 8*20 хэмжээтэй хүлэмж, услалтын системийн тоног төхөөрөмжтэй болно	Богд сумын Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор 8*30 хэмжээтэй автоматжуулсан хүлэмж, иж бүрэн усалгааны систем, 12 тн багтаамжтай ус хуримтлуулах савыг тус тус байршуулсан. Ингэснээр говийн бүсэд тохирсон модны тарьц, суулгац бэлтгэж говийн сумдад нийлүүлэх боломж бүрдсэн.	100%
91		4.1.5. Бүх нийтээр мод тарих хавар намрын өдрүүд, дэлхийн усны өдөр, Мазаалай хамгаалах өдөр, нүүдлийн шувуудыг хамгаалах өдөр, Цаг уурчдын өдөр, ирвэс хамгаалах өдөр, ой, ургамал хамгаалах өдөр зэрэг салбарын 28 тэмдэглэлт өдрүүдээр	Танхимын болон цахим сургалтыг 60-аас доошгүй удаа зохион байгуулж нийт 10000 иргэнд хүргэсэн байна.	Бүх нийтээр мод тарих хавар намрын өдрүүд, Дэлхийн усны өдөр, Мазаалай хамгаалах өдөр, Нүүдлийн шувуудыг хамгаалах өдөр, Цаг уурчдын өдөр, Ирвэс хамгаалах өдөр, Ой, ургамал хамгаалах өдөр зэрэг нийт 13 өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, цахим болон танхимын 125 сургалт зохион байгуулж 12503 иргэд, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, Сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийг хамруулж байгаль орчныг хамгаалах суурь мэдлэгийг олгосон. Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар 12 удаагийн мэдээллийг улсын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 300 орчим мэдээллийг цахим хуудсаар мэдээлж давхардсан тоогоор 300.0 мянган хүнд хүргэсэн байна.	100%
1	2	3	4	5	6

		сургалт сурталчилгаа хийх			
92		4.1.6. Түйн голын бургасанд хортон шавьжны устгал хийх	Түйн голын бургасны хортон шавжийн устгалыг 3.5 га талбайд хийлгэж байгалийн аясаар сэргэн ургах нөхцөлийг бүрдүүлнэ.	Түйн гол дагуух цагаан бургасанд ойн хөнөөлт шавжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхэд бургас хүр эрвээхэйн голомттой байгаа төдийгүй 50 хувь нь идэгдсэн дүгнэлт гарсан. Иймд түйн гол дагуух цагаан бургас бүхий нийт 3.3 га талбайд ойн хортон шавжийн устгалын ажлыг Сайхан ойн төлөө ХХК-аар хийлгэж, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газраас хяналт тавьж ажилласан. Уг ажил хийгдсэнээр ховордож буй цагаан бургас сэргэн ургах бүрэн боломж бүрдсэн.	100%
93		4.1.7. Түйн голын байгалийн үерээр эвдэгдсэн хэсгийг шулуутгах	Богд сумын Хориултаас татуурга хүртэл 500м зайд Түйн голыг үндсэн голдиролд оруулж голын ай савыг хэвийн голдиролд оруулсан байна.	Богд сумын "Татуургын булаг"-ийн эх орчимд 1.5м өргөн 400метр урттай, 96 метр доторлогоотой далангийн ажлыг Тэгш буянт очир ХХК-аар хийж гүйцэтгэн Хориулт орчмын (Хориултаас татуурга хүртэл 500м зайд) байгалийн үерээр эвдэгдсэн голын голдирлыг үндсэн голдиролд оруулж, хээрээр ус алдалтыг зогсоон булгийн эхийг хамгаалсан.	100%
94		4.1.8. Байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тооцуулах.	Байгаль орчинд учруулсан үнэлгээг тооцуулан гарсан хохирлыг бүрэн барагдуулах.	Баянхонгор сумын нутагт орших Шатахуун түгээх станцууд болон Шинэ суурьшлын бүсийн авто замд ашигласан карьерт Байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг "Грийн ассесмент" ХХК хийж гүйцэтгэн 33.9 сая төгрөгийн нөхөн төлбөр тооцож 2022 оны 11 сард Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар хүлээлгэн өгсөн, одоогоор төлбөр ороогүй байна.	100%
95		4.1.9. Аймгийн хэмжээний цөлжиж буй газрын судалгааг хийлгэх	Аймгийн нутаг дэвсгэрт цөлжиж буй газрын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, хүлээн авсан байна.	Аймгийн хэмжээний цөлжиж буй газрын судалгааг хийлгэхээр 3 удаа тендер зарлагдсан боловч материал ирүүлээгүй. Иймд уг ажлын нэмэлт санхүүжилтийг "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төслийн 2023 оны төлөвлөгөөнд тусгаж нийт 60.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийлгэхээр төлөвлөсөн. Үүний дагуу энэ онд Шинжлэх ухааны академийн Газарзүй-Геоэкологийн төвтэй гэрээ байгуулсан.	50%
96		4.1.10. Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус ашиглалтад байнгын	Усны боломжит нөөцөд тохирсон ус ашиглалт, ус ашиглах гэрээ, ус бохирдуулсны.	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд -3 удаа, Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд - 5 удаа, Ундны усны эх үүсвэрүүдэд- 3 удаа нийт 11 удаагийн хяналт шалгалтыг хийж	
1	2	3	4	5	6

		хяналт тавих	төлбөрийн гэрээний биелэлтийг хянах, ус, рашаан ашигласны болон ус бохирдуулсны төлбөрийн биелэлтэд сар бүр хяналт тавина	гүйцэтгэсэн.Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хяналт шалгалтаар ус ашиглуулах дүгнэлт, хаягдал усны дүгнэлт гаргуулж ажиллаагүй-1, өмнөх оны төлбөр дутуу-3, гэрээ дүгнүүлээгүй-3, цооногийг тоолууржуулж баталгаажуулаагүй-5, баталгаажуулсан тоолуур зөвшөөрөлгүй салгаж өөр тоолуур суурилуулж ус ашигласан-1, нийт 13 зөрчил илэрсэн бөгөөд илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулсан. Амралт, аялал жуулчлал, рашаан сувиллын газруудад 5 удаа давхардсан тоогоор 17 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан. Шалгалтын явцад Шаргалжуут голын хамгаалалтын бүсэд суурьшлын бүс үүсгэн хашиж хамгаалсан талбайг чөлөөлүүлэх, нүхэн жорлонг буулгах ажлыг зохион байгуулсан. Ундны усны эх үүсвэрүүдэд 3 удаагийн хяналт шалгалт хийсэн бөгөөд шалгалтын явцад Галуут сумд газрын доорх усны нөөц тогтоогдсон ордын гадаад тэжээгдлийн мужид хогийн цэг үүсгэснийг нүүлгэн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж ажилласан. Энэ онд Бөөнцагаан-Орог нуурын сав газарт 17 томоохон аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулснаас Ус рашаан ашигласны төлбөр 498,0 сая төгрөг төвлөрсөн. Усны газрын дүгнэлтийг үндэслэн уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 4, рашаан сувиллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 1, нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхлэх 1, нийт 7 аж ахуй нэгжид 582 933.8 м3 хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулан ажилласан. Ус бохирдуулсны төлбөрийг орлого Усны газрын дүгнэлтээр 6.8 сая төгрөг, сав газрын захиргааны дүгнэлтээр 8.4 сая төгрөг, нийт 15.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Ус ашиглах гэрээ болон Ус бохирдуулсны гэрээнд сар бүр хяналт тавин жилийн эцэст гэрээг дүгнэн ажилласан.	100%
97		4.1.11. Бөөнцагаан нуур-Байдраг голын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батловсруулах	Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж эхэлснээр аймгийн хэмжээнд усны талаар баримтлах	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, "Монхидроконстракшн" ХХК –тай хамтран Бөөнцагаан нуур-Байдраг голын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулж дууссан. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө батлагдсаны дараа Бөөнцагаан нуур-Байдраг голын усны нөөцийн	70%
1	2	3	4	5	6

			бодлогын баримт бичигтэй болсон байна.	нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлахаар хүлээгдэж байна.	
98		4.1.12. Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Гангийн эрсдэл буурна.	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг Баян-Бороо -1,2 экспедици 8 удаа, Баянцагаан газрын генератор 2 удаа явуулсан. Үр дүнд нь 5 дугаар сард аймгийн нийт нутгийн 35-50 хувийг хамруулан хур тунадсыг нэмэгдүүлсэн. Харин 07 дугаар сард Хориулт, Жинст сумын нутгаар олон жилийн дунджаас 6.0-12.0 миллиметрээр их, 08 дугаар сард Галуут, Баянцагаан сумын нутгаар олон жилийн дунджаас 3.0-9.0 миллиметрээр их хур тунадас орж гангийн эрсдэл буурсан. Бусад нутгаар олон жилийн дунджийн орчим буюу бага хур тунадас орсон. Энэ онд Зүсэр борооны давтагдал эрс багасаж, Түр зуурын аадар бороотой, баруун өмнөдийн доод болон дунд мандлын үүлний масс цөөхөн тоотой орж ирж, үүл нь услаг багатай шилжсэнээс, бэлчээрийн даац хэтэрч зуншлага тааруу болоход хүргэсэн байна.	70%
99		4.1.13. Бөөнцагаан нууранд шувуу ажиглах байр барих	Бөөнцагаан нуурыг аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлсэн байна.	“Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах” төслийн санхүүжилтээр” Монголын махчин шувуу асран хамгаалах төв” НҮТББ Баацагаан сумын Бөөнцагаан нуурын эрэгт шувуу ажиглах цамхгийг 11 дүгээр сард хийж гүйцэтгэсэн. Шувуу ажиглах цамхгийг байршуулснаар Бөөнцагаан нуурыг түшиглэн тусгай зориулалтын аялал жуулчлал хөгжих боломжийг бий болгосон.	100%
100		4.1.14. Зэрлэг амьтдын байршил бүхий газруудад өвс, хужир тавьж өгөх (биотехникийн арга хэмжээ авах)	Амьтад идэш, тэжээлийн хомсдолд орохоос сэргийлж, амьдрах орчныг сайжруулна.	Аймгийн хэмжээнд 2022 оны 01-р сарын 05-ний өдрөөс 04-р сарын 01-ний өдрийн хооронд Бууцагаан, Баянцагаан сумдад 1 удаа, Баянбулаг, Галуут, Эрдэнэцогт сумдад 2 удаа, Жаргалант, Өлзийт сумдад тус тус 3 удаа нийт 10.5 тонн хужир, 120 боодол өвс, 65 кг жамц давсаар биотехникийн арга хэмжээ авч зэрлэг амьтдын тархац нутагт байршуулсан. Мазаалай баавгайн амьдрах орчны бүсэд 2022 оны 05 дугаар сарын 01-05-ны хооронд 7 цэгийн 11 тэжээлийн саванд, 28 шуудай хорголжин тэжээлийг байршуулан биотехникийг арга хэмжээ авч ажилласан. Энэ оны 12 дугаар сард биотехникийн арга хэмжээг дахин авах 350 боодол өвс, 15 тонн хужир, 50 шуудай хорголжин тэжээлийг сумдад хуваарилан өгсөн. Биотехникийн арга хэмжээ авч амьтдын идэш тэжээлийн хомсдолоос сэргийлж ажилласнаар амьтдын нүүдэллэн шилжих хөдөлгөөн багасаж, тогтвор суурьшилтай амьдрах орчин бүрдсэн.	100%
1	2	3	4	5	6

101		4.1.15. Аялал жуулчлалын нөөц газруудын судалгааг эрдэмтдийн багтай хамтран хийх	Аймгийн аялал жуулчлалын онцлог нөөц газрууд, эрдэм шинжилгээний тодорхойлолттой болж, эдийн засгийн эргэлтэд орох нөхцөл бүрдэнэ.	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх "Аялал жуулчлалыг дэмжих эрдэмтдийн зөвлөл", аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Баянхонгор-Хүн үүслийн өлгий” аялал жуулчлалын холбоо хамтран тус аймгийн аялал жуулчлалын нөөц газруудын судалгааг хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд археологийн болон байгалийн содон тогтоц бүхий 6 газрыг шинээр илрүүлж, "Монголиан Хайленд тур оператор" ХХК 2023 оны аяллын маршрут, хөтөлбөртөө тус газруудыг тусгахаар болсон. Мөн судалгааны ажлыг зохион байгуулснаар судалгаанд хамрагдсан нөөц газруудыг цаашид хэрхэн хамгаалах, сурталчлах, эдийн засгийн эргэлтэд оруулан аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох, эрдэм шинжилгээний тодорхойлолттой болгох эхний суурь материалыг бүрдүүлж, аймгийн гэрэл зураг, видео мэдээллийн санг нэмэгдүүлсэн.	100%
102		4.1.16. Аялал жуулчлалын нөөц газар Их Богд хайрхны Цонж орчмыг тохижуулж, аяллын маршрутыг тогтоох	Дотоод, гадаадын аялагчдын аялах нөхцөл бүрдсэн байна.	Тус аймгийн аялал жуулчлалын нөөц газар болох Их Богдын Байгалийн цогцолборт газрын Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрхныг түшиглэн аялал жуулчлалын отоглох цэг байгуулсан. Энэхүү Их Богд уулын Цонж орчмыг тохижуулж отоглох цэг байгуулснаар дотоод, гадаадын жуулчдын амрах, аялах тав тухтай орчныг бүрдүүлсэн төдийгүй байгаль орчныг хамгаалж, бүс нутгийн эдийн засаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн.	100%
103		4.1.17. Аялал жуулчлалын эвент арга хэмжээ, сарлагийн баяр, өвлийн наадам, тэмээний баяр, Ай Ти Эм арга хэмжээнд оролцох	Дотоодын аялагчдыг 72 мянга, гадаадын аялагчдыг 500-д хүргэсэн байна.	Дотоодын аялал жуулчлалын "Улаанбаатар Трэвел Экспо" үзэсгэлэнд 2022 оны 05 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд, аялал жуулчлалын Олон Улсын арга хэмжээ болох "Ай Ти Эм-2022" үзэсгэлэнд 2022 оны 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд тус тус оролцож аймаг, орон нутгаа жуулчдад сурталчилж ажилласан. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнд оролцсоны үр дүнд энэ онд тус аймагт 46228 дотоодын аялагч, 1271 гадаадын аялагч хүрэлцэн ирсэн нь өмнө оноос 3 дахин өссөн дүнтэй байна. Энэ онд аялал жуулчлалаас 1,8 тэрбум төгрөгийн орлого орсон энэ нь өмнөх оны мөн үеэс 19 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%
104		4.1.18. Аймгийн хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн	Хог хаягдлын улмаас эвдэрсэн 6 га газрын техникийн болон	Аймгийн хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх ажлын санхүүжилт энэ онд шийдвэрлэгдээгүй. Аймгийн 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд санхүүжилтийг	0%
1	2	3	4	5	6

		сэргээлтийг хийх	биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийсэн байна.	шийдвэрлэж тусгасан	
105		4.1.19. Шинэ хогийн цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулах	Стандартын шаардлага хангасан ландфилийн хогийн цэгийг стандартын дагуу хийсэн байна. /100м*100м буюу 5 га газар/	Баянхонгор сумын төвлөрсөн шинэ хогийн цэгийг Шинэ суурьшлын бүсээс 13 км зайд Өлзийт сумын 1-р багийн нутаг дэвсгэрт 70 метр өргөнтэй, 100 метр урттай, 4 метрийн гүн, 4 метрийн өндөр далан бүхий нийт 8 метрийн гүнтэйгээр стандартын шаардлагад нийцүүлэн “Талын нөмөр” ХХК хийж гүйцэтгэсэн. Хуучин хогийн цэг нь Шинэ суурьшлын бүсийн зонхилох салхины дээр байсан тул суурьшлын бүс рүү хог орж ирэх эрсдэлтэй тул хаасан.	100%
106		4.1.20. Баянхонгор сумын 9 багт хоёрдогч түүхий эд худалдан авах цэгүүдийг байгуулах	Хоёрдогч түүхий эд худалдан авах 6 цэгийг бий болгон хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж, хог хаягдлыг багасгана.	Баянхонгор сумын 9 багт хоёрдогч түүхий эд худалдан авах цэг байгуулах ажлын хэсэг байгуулагдаж баг бүрд хоёрдогч түүхий эд худалдан авах цэгийн байршлыг сонгосон боловч хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй. Энэ онд Баянхонгор сумын нутаг дэвсгэрт хоёрдогч түүхий эд худалдан авдаг 2 аж ахуйн нэгж, 1 иргэн 3 цэгт үйл ажиллагаа явуулж байна. “Хонгор дуулим” ХХК, “Талстболор” ХХК шил /бүх төрлийн шил/ 300.000 ширхэг, хуванцар 247.2 кг, гялгар уут 13.3 кг, лааз 71.1 кг худалдан авалт хийж Улаанбаатар хот руу ачиж тээвэрлэн Ховд ХХК, Шинэ шил, Апу, Эм Си Эс ХХК, Жэм интернэйшнл, Эко пластик, Юу Си Жи ХХК-нд нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулсан байна.	50%
107		4.1.21. Зорилтот өрхийг чип /CHIP/ багцаар хангах /оролцоо/	Зорилтот бүлгийн 100 өрхийг багцаар хангаж утааг бууруулахад хувь нэмэр оруулсан байна.	2022 онд Баянхонгор аймаг 130 өрхийг ЧИП багцад хамруулахаар Аймгийн төсвөөс 150 сая төгрөг НҮБ-ын хүүхдийн сангийн дэмжлэгээр 100 сая төгрөгийн авч 2022 оны 1-р улиралд багтаан тендер зарлаж “Буянт хөрс наран” ХХК, “Хонгорын оргилд хүрэх зам” ХХК-ууд шалгарч тус оны 8 сард багц бүтээгдэхүүнийг бүрэн хүлээн авч айл өрхүүдэд нийлүүлсэн байна. 2019 оны 10 сараас хойш нийт 602 айлыг Халаалт, дулаалгын багцад хамруулж Баянхонгор аймгийн төвийн гэр хорооллын өрхийн 10 хувийг хангаад байна. 2019-2022 онд Баянхонгор аймгийн хэмжээнд багцад хамрагдсан нийт 602 өрхийн 40 хувь нь бага насны хүүхэдтэй, 38 хувь нь ахмад настан, 17 хувь нь өрх толгойлсон эцэг эх, 5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус эзэлж байна. Төсөлд хамрагдсан өрхийг нүүрс түлдэг өрхүүдтэй харьцуулсан судалгаанаас харахад тухайн өрхийн гишүүдийн амьсгалын замын өвчлөл 30 хувь буурсан	100%
1	2	3	4	5	6

				үзүүлэлттэй байна.	
108		4.1.22. Төв зам дагуу хогийн сав байрлуулах	Ангилан ялгалт бүхий багтаамж сайтай стандартын шаардлага хангасан хогийн савыг шинээр байршуулах	Иргэдэд хог ангилан ялгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төв зам дагуу 2 төрлөөр ангилан ялгах боломжтой 88 ширхэг хогийн сав, нийтийн орон сууцны гадна 3 төрлөөр ангилан ялгах боломжтой 12 ширхэг хогийн сав нийт 100 ширхэг хогийн савыг байршуулж орчны эрүүл ахуйг сайжруулах нөхцөлийг бүрдүүлсэн.	100%
109		4.1.23. Төв зам дагасан хайлсан хашлаганы дагуу буй явган хайсыг авч амьчуулын баруун талын замын дагасан нарс моднуудыг хаших	Тус хайсыг шилжүүлснээр Угалз багийн засмал зам дагуух ногоон байгууламжийг хамгаална.	Төв зам дагуух хайлаас модны 659*0.6 м хэмжээтэй хайс хамгаалалтыг Монгол банкны уулзвараас Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг хүртэл, Модерн төвөөс төв уурын зуух хүртэл шинээр тарьсан хайлаас модны хамгаалалтад шилжүүлж суурилуулсан.	100%
110		4.1.13. Шинэ суурьшлын бүсэд худаг гаргах	Тарьсан модны ургалтын хувь нэмэгдэнэ.	Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн хамгаалалтын ойн зурвасын усалгаанд шаардлагатай худгийг “Гео Дата процессинг” ХХК гаргаж, 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр цооногийг ашиглалтад оруулсан. Худаг гаргаснаар тус хамгаалалтын зурваст тарьсан модны ургалтын хувийг 85 хувьд хүргэсэн. Цооногийн мэдээлэл: диаметр 159, гүн нь 60 метр, насосны хүчин чадал нь 0.75 квт, 750м2 талбайг услах хүчин чадалтай.	100%
ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
111	5.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал	5.1.1. Арван мянгатын хатуу хучилттай 1.2 км зам дагуу явган хүний зам барих, босоо бордюр хийх	Баянхонгор сумын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Дуурсах, Гэгээн шавь багуудын дундуур 10 мянгат чиглэлд “Тэнгэрийн -Уул” ХХК нь 1.2 км явган хүний алаг чулуун замыг замын сангийн 165.9 сая төгрөгийн хөрөнгөөр барьж, хатуу хучилттай авто зам дагуу босоо хашлага хийх ажлыг гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулж, замын чанар сайжирч, иргэдийн ая тухтай зорчих нөхцөл бүрдсэн.	100%
112		5.1.2. Аймгийн төв доторх эвдэрсэн 1000м2 талбайд замын нөхөөс хийх	Авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.	Аймгийн төв доторх эвдэрсэн 1000м2 талбайд замын нөхөөс хийх ажлыг замын сангийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр бүрэн гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Замын чанар сайжирсан.	100%
113		5.1.3. Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвар хүртэл 900 метрт хатуу хучилттай	Баянхонгор сумын өнгө үзэмж сайжирч авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.	Аюулгүйн тойргоос Нэгдсэн эмнэлгийн баруун талын уулзвар хүртэлх 900м хатуу хучилттай авто замыг шинэчлэн барих ажлыг замын сангийн 501.1 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Замын чанар сайжирч, иргэдийн ая тухтай зорчих боломж бүрдсэн.	100%
1	2	3	4	5	6

		авто замыг шинэчлэх			
114		5.1.4. Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын урд уулзвар хүртэлх 750 метр замд хатуу хучилттай авто зам барих	Баянхонгор сумын өнгө үзэмж сайжирч авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн байна.	Онцгой байдлын газрын уулзвараас Хүнс, хөдөө аж ахуйн газрын уулзвар хүртэлх 750м хатуу хучилттай авто зам барих ажлыг замын сангийн 451.8 сая төгрөгийн хөрөнгөөр бүрэн дуусгаж байнгын ашиглалтад оруулсан. Баянхонгор сумын өнгө үзэмж сайжирч авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдсэн байна	100%
115		5.1.5. Есөн-Эрдэнэ захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх зам дагуу явган хүний зам хийх	Хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Есөн-Эрдэнэ захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх 1200 м хатуу хучилттай авто замд хучилт хийх ажлыг замын сангийн 514.6 сая төгрөгөөр бүрэн дуусган ашиглалтад оруулсан. Замын чанар, зорчих нөхцөл сайжирсан.	100%
116		5.1.6. Эрдэнэмандал сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах	Зам тээврийн осол буурч, хүний эрх хангагдсан байна.	Баянхонгор сумын 1 дүгээр багийн Эрдэнэмандал ахлах сургуулийн сургууль орчмын бүсийн явган хүний гарцыг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах ажилд Орон нутгийн Өмчийн газраас тендер шалгаруулалтыг зарлаж “Итгэлт тайж” ХХК шалгарч Замын сангийн 28.1 сая төгрөгөөр 2022 оны 08 дугаар сард тохижуулж ашиглалтад оруулсан.Олон нийтийн зорчих замын стандартын шаардлага хангагдсан.	100%
117		5.1.7. Аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах	Нэн шаардлагатай 350 м2 уулзвар, орц гарцыг шинэчилнэ.	Баянхонгор сумын уулзвар гарцуудыг засварлах ажлыг Замын сангийн 138.1 сая төгрөгөөр гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан. Замын уулзвар гарцын зорчих хэсэг стандартын шаардлага хангагдсан.	100%
118		5.1.8. Шаардлагатай сумдын шороон замын зураг төсөв боловсруулах, засвар үйлчилгээ хийх (Баянговь, Баянлиг, Баацагаан, Баянцагаан, Шинэжинст, Эрдэнэцогт,Баян-Өндөр)	Зураг төсөв боловсруулагдсан байна. Байгалийн гамшгаар эвдэгдсэн шороон замууд засагдсанаар иргэдийн аюулгүй зорчих боломж бүрдэнэ	Энэ онд ОНХСанд хөрөнгө суугдсан боловч 2022 оны 04 сарын 29-ны өдөр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоолын 1.4-т зааснаар хэрэгжих боломжгүй болсон.	0%
1	2	3	4	5	6

119		5.1.9. Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх	Шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай 10 км авто замын ажлыг эхлүүлсэн байна.	Улсын төсвийн 1800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсийн 10км хатуу хучилттай авто замын угсралтын ажлыг "Түм дэлгэрэх" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. Тус ажлын газар шороо, далан сувгийн ажлууд тус тус хийгдсэн. Энэ онд төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдсэн.	100%
120		5.1.10. Шаргалжуут тосгоны замын засвар хийх	Амрагчдын ая тухтай, осол авааргүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Шаргалжуут 8-р багийн тосгоны доторх замын чулуу, үерт идэгдсэн гүүрний засварын ажлыг замын сангийн 5.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж, бүрэн дуусган ашиглалтад оруулсан.	100%
121		5.1.11. Хот хоорондын ачаа, тээвэр, сум хоорондын тээвэр, нүүрс, түлээ, амьд мал худалдаалах нэгдсэн цэг байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх	Нэгдсэн зохион байгуулалтад орж аймгийн төлөвлөлт, өнгө үзэмж сайжирна.	Аймгийн баруун талд авто замын чиглэлд амьд мал худалдаалах нэгдсэн 1 цэгийг байгуулсан. Мөн Баруун бүс худалдааны төвийн урд ачаа тээвэр, нүүрс түлээ зарах цэг ажиллаж байна.	70%
122		5.1.12. Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээг хийх	Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц сайжирч иргэд хувийн байр сууц барьж ая тухтай амьдрах орчин бүрдэх эхлэлийг тавина.	Шинэ суурьшлын бүсийн барилга, инженерийн шугам сүлжээний ажлыг "Гал хонгор" ХХК-тай гэрээ байгуулан угсралтын ажлыг эхлүүлээд байна. Тус ажлын хүрээнд ингэний сүүний үйлдвэрийн барилга, 640 хүүхдийн суудалтай сургууль, 14 ортой эмнэлгийн барилга, 200 айлын 2 нийтийн орон сууцны барилгуудыг дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг тус тус хийж гүйцэтгэн ашиглалтад оруулаад байна. Тайлант онд төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдсэн.	100%
123		5.1.13. Баянхонгор сумын инженерийн шугам сүлжээний тооллогын ажлыг эхлүүлж мэдээллийн санд оруулах	Шугам сүлжээний насжилт, өндөржилтийг бүрэн тооцох боломж бүрдэнэ.	Аймгийн хэмжээнд бүх шугам сүлжээний тооллого хийх, шинээр ашиглалтад орсон барилгуудын гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэн мэдээллийн санд хүлээн авсан. Баянхонгор сумын цэвэр усны төв шугам 16.4 км шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг "Ди эм ти эй инженеринг" ХХК, "Чандмань-Баянхонгор" ХК 15.0 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгэж Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн санд хүлээлгэн өгсөн. Мөн Баянхонгор сумын цахилгааны шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг хийлгэхээр "Лэнд форм сүрвэй" ХХК-тай "Баянхонгор Эрчим хүч" ЦТХХК 19.0 сая төгрөгөөр гэрээ байгуулан ажлыг	100%
1	2	3	4	5	6

				гүйцэтгүүлсэн.	
124		5.1.14. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийг хийх	Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг эхлүүлсэн байна.	Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчээр "ДИ ЭМ ТИ ЭМ" ХХК шалгаран гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. Тайлант онд төлөвлөгдсөн ажил бүрэн хийгдсэнээр цахилгааны эх үүсвэрийн найдвартай байдал хангагдсан.	100%
125		5.1.15. Шаардлагатай газруудад цахилгаан шугам, дэд станцын өргөтгөл хийх (5.6 км иж бүрэн шугам, 2 дэд станцын өргөтгөл хийх)	300 орчим хэрэглэгчдийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж, хүчдэлийн түвшинг сайжруулна.	Баянхонгор сумын 4, 5, 7, 9 дүгээр багуудад эрчим хүчний чадлыг сайжруулж, дэд станцын өргөтгөл хийх ажлыг "Гарьд системс" ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 09 дүгээр сард байнгын ашиглалтад оруулсан. Ингэснээр Баянхонгор сумын 300 орчим хэрэглэгч найдвартай эрчим хүчээр хангагдсан.	100%
126		5.1.16. Баацагаан сумын цаг уурын тоног төхөөрөмжийг шинэчлэх	Автомат станц тавьснаар цаг уурын мэдээллийг шуурхай авах нөхцөл бүрдэнэ.	Баацагаан сумын Баянсайр цаг уурын харуулын өртөөнд агаар, хөрсний температур, чийг, тунадас хэмжигч цаг уурын автомат Q1000 станцыг байрлуулсан. Станц байгуулагдсанаар Дэлхийн цаг уурын гэрээний дагуу олон улсын цаг уурын мэдээллийг минут, секундээр гаргаж Олон улсын цаг уурын байгууллагад мэдээлэх боломж бүрдсэн. Мөн тус сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр харуулын талбай 6*8 байсныг автомат станцын стандартад нийцүүлэн 26*26 болгон томруулсан.	100%
127		5.1.17. Хүрээмарал сумын Сувраа уулын орой дахь Жи-Мобайлын сүлжээг дахин дамжуулах станцын өргөтгөл шинэчлэл хийх	Баянбулаг, Гурванбулаг, Заг, Бууцагаан сумдын багийн иргэд Жи-Мобайлын сүлжээг ашиглах боломжтой болно.	Хүрээмарал сумын Сувраа уулын оройд үүрэн холбооны сүлжээний дахин дамжуулах станцын өргөтгөл шинэчлэл ажлын гүйцэтгэгчээр "Жи-Мобайл" ХХК ажиллаж 2022 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулснаар үүрэн телефоны шинэ сүлжээ ашиглах боломжтой болсон.	100%
128		5.1.18. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	Дулааны станцын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	Баянхонгор аймагт байгуулах 35МВт хүчин чадалтай дулааны станцын ТЭЗҮ боловсруулалтын ажил хийгдэж дууссан. Дулааны станцын 2-р хэлхээний шугам сүлжээний зураг төслийн ажлыг "Ричвелл инженеринг" гүйцэтгэн 2021 онд ажлын зургийг хүлээн авсан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын "Бьюксан Инженеринг" ХХК, "МЭЗ" ХХК нар ажиллаж байгаа бөгөөд тайлант оны гүйцэтгэх ажлын хүрээнд Баянхонгор аймгийн туслан гүйцэтгэгчээр "Эх бүрдэн" ХХК болон "Гурван Тахилгат Оргил" ХХК-	100%
1	2	3	4	5	6

				иуд түншлэлийн гэрээ байгуулж 2022 оны 9-р сард барилгын суурийн ажил дууссан ба хөрс нягтруулалт, шороо булалтын ажил хийгдсэн. Графикийн дагуу 2022 онд хийгдэх ажил бүрэн дууссан.	
129		5.1.19. Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх	Иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх таатай орчин нөхцөл бүрдсэн байна.	Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг "Нью бест хаус" ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 07 дугаар сард улсын комисс ажиллуулж байнгын ашиглалтад оруулснаар иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх таатай орчин бүрдсэн.	100%
130		5.1.20. Баацагаан, Галуут, Эрдэнэцогт сумдад "Сумын төвийн шинэчлэл" төсөл хэрэгжүүлэх	Галуут, Эрдэнэцогт сумдын сумын төвийн шинэчлэлийн ажлыг ашиглалтад оруулж Баацагаан сумын сумын төвийн шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн байна.	2021 онд Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр "Бридж бюлдинг" ХХК шалгаран, түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан. Зураг төслийн ажлыг "Гидрогеодизайн инноваци" ХХК гүйцэтгэн 2км автозамын зураг төслийн ажлыг боловсруулан батлуулсан. 2022 онд 60-70 м3 хүчин чадалтай "Экологос"-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө хийх, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800м урттай дугуйн зам, 2.5 км авто зам, 2.5 км урттай бохирын шугам, Усан хангамжийн эх үүсвэрийн 25м3 багтаамжтай нөөцийн сав /Хуучин эх үүсвэр ашиглах/, Цэвэрлэх байгууламж ажиллуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд хийгдэх бөгөөд шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдсэн. 2023 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2021 онд Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтад "Алегротовер констракшин" ХХК шалгарсан бөгөөд Түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр гэрээ байгуулсан. Сумын төвийн шинэчлэлийн ажлын зураг төсөл боловсруулах ажлыг "Алтайн газрын хүч" ХХК гүйцэтгэж дууссан бөгөөд Барилгын хөгжлийн төв дээр магадлалын дүгнэлт гаргуулахаар хянагдаж байна. Тус төслийн хүрээнд 2 км авто зам /гэрэлтүүлэг, камер, ногоон байгууламжтай/ 2 км дугуйн зам, 2 км явган зам, Бохирын шугам 2 км, 60м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж, Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, 60м3 багтаамжтай нөөцийн сав, 2км урттай цэвэр болон дулааны шугамын ажлууд хийгдсэн. 100м*70м, 90м*60м талбайтай 2 цэцэрлэгт хүрээлэн, Албан байгууллагуудын ариун цэврийн өрөө шинээр хийх /6 байгууллагын барилгад 12	90%
1	2	3	4	5	6

				нойлын өрөө/ ажлууд 2023 онд хийгдэнэ. Энэ онд Баацагаан сумын СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ-ийн сонгон шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зохион байгуулж, “Рино инженеринг” ХХК шалгаран 5 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. Зураг төслийн гүйцэтгэгчээр “Аркон” ХХК болон Төгс орхон ХХК ажиллаж Ерөнхий төлөвлөгөө, суурь судалгааны ажил хийгдэж дууссан.	
131		5.1.21. Баацагаан сумд орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх	Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлсэн байна.	Баацагаан сумыг орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлын гүйцэтгэгчээр “Шинэ Өлгийн зам” ХХК шалгаран гэрээ байгуулсан. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон зураг төсөл боловсруулалтын ажил хийгдэж байна. 2023 онд Барилга угсралтын ажил эхлүүлэхээр төлөвлөсөн.	50%
132		5.1.22. Шинэ суурьшлын бүсэд А, Б блок 1500 айлын 30 орон сууцны хорооллыг байгуулах	2 нийтийн орон сууцны барилгыг байнгын ашиглалтад оруулж, шинээр 2 барилгын угсралтын ажлыг эхлүүлсэн байна.	Шинэ суурьшлын бүсэд 106 айлын 2 блок орон сууцны барилгын угсралтын ажлыг “Хаш гоёо” ХХК, Баянхонгор эко дулаан ХХК 2021 онд эхлүүлсэн бөгөөд 2022 оны 10 сард улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулсан.	100%
133		5.1.23. Аймгийн ашиглалтын шаардлага хангахааргүй болсон хуучин барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх	Баянхонгор сумын 10 дугаар байрыг ашиглалтад оруулж, 1 дүгээр байрыг дахин төлөвлөлтөд оруулах ажлыг эхлүүлсэн байна.	Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг буулган шинээр 125 айлын орон сууц барихаар барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр “Зүүн шанд” ХХК, “РМБ” ХХК шалгаран барилга угсралтын ажлыг эхлүүлээд байна. Тус барилгыг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан байнгын ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Рашаант 10-р багийн 1-р байрны дахин төлөвлөлтийн ажлын гүйцэтгэгчээр “Би ай эм би” ХХК шалгарсан бөгөөд Аймгийн засаг дарга, оршин суугчид, гүйцэтгэгч 3 талт гэрээ байгуулан, буулгалтын ажлыг 2022 оны 04 сард хийж, 7 давхар 49 айлын орон сууцны угсралтын ажлыг эхлүүлсэн ба 2023 оны 1-р улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Гүйцэтгэл 85 хувь . Мөн Рашаант 10-р багт 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлсэн. 7 давхар 4 блок орон сууцны хотхоны зураг төслийн гүйцэтгэгчээр ХХК, барилга угсралтын гүйцэтгэгчээр “Хаш гоёо” ХХК ажиллаж байна. 1-р ээлжийн 2 блок 80 айлын орон сууцны барилгыг 2022 оны 4 улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. 2-р ээлжийн 2 блок 80 айлын орон сууцны барилгын	90%
1	2	3	4	5	6

				гүйцэтгэл 50 хувьтай үргэлжилж байна. Тус ажил нь 2023 оны 2-р улиралд ашиглалтад оруулна.	
134		5.1.24. Баянхонгор сумын Номгон 1-р багийн 514 дүгээр байрыг их засварт оруулах	Иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багийн 514 дүгээр байрны засварын ажлыг "Алегротовер констракшн" ХХК гүйцэтгэн 2022 оны 07 сард улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулсан. Уг их засварын ажлыг хүрээнд Бохирын шугам сүлжээ солих, гадна фасад, дээвэр, орцны дотор заслын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.	100%
135		5.1.25. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл	Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэх хийх санхүүжилт нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд татагдсан.	0%
136		5.1.26. Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлэх	Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлсэн байна.	Улсын төсвийн 27.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Б софт" ХХК шалгаран гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн ба тайлант оны төлөвлөгөөт ажил бүрэн хийгдсэн.	100%
137		5.1.27. Баянхонгор аймгийн төвд шинэ суурьшлын бүс бий болж байгаатай холбоотойгоор ус хангамжийн эх үүсвэрт 5 дахь худаг гаргах	Ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлсэн байна.	Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж шинээр нэг худаг гаргах ажлыг хандивын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх байсан боловч энэ онд хөрөнгө төлөвлөсөн хэмжээнд бүрдээгүй тул хэрэгжих боломжгүй болсон.	0%
138		5.1.28. Баянхонгор сумын ундны усны харуул хамгаалалт	Аймгийн нийт хүн амын ундны ус нь эрүүл, аюулгүй байна.	Баянхонгор сумын иргэдийг цэвэр, аюулгүй ундны усаар хангах зорилгоор ундны усны эх үүсвэрийн худгийн аюулгүй байдлыг "Даяар трейд" ХХК хариуцан ажиллаж байна. Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангаснаар иргэд, хөдөлмөрчид эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангагдах нөхцөл бүрдэж байна.	100%
139		5.1.29. Үүрэн холбооны сүлжээ	Хөдөөгийн малчид гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ	Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймгийн хөдөөгийн 10 сумын 10 багт үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Юнител" ХХК шалгаран гэрээ байгуулсан. Үүрэн холбооны	50%
1	2	3	4	5	6

				шугам сүлжээний ажлыг 2023 оны 04 дүгээр сараас эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулаад байна.	
140		5.1.30. Оготнотой булаг орчмын тоглоомын талбайн 55 автомашины зогсоол	Булаг орчмын бүсэд автомашины хөдөлгөөний урсгалыг хязгаарлах нэгдсэн зогсоолтой болно.	Оготнотой булгийн хүүхдийн тоглоомын талбайд хатуу хучилттай 55 авто машины зогсоолыг "Их богд зам" ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 07 дугаар сард хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.	100%
141		5.1.31. Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх	Авто зам ашиглагчдын аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.	Аймгийн төвийн эвдэрсэн зам талбайн ажлын гүйцэтгэгчээр "Их богд зам" ХХК шалгаран 1200м2 талбайд нөхөөсний ажил хийж гүйцэтгэн 2022 оны 07 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулсан.	100%
142		5.1.32. Номгон хайрхны өврийн замын засвар	Иргэдийн аюулгүй зорчих нөхцөл бүрдэнэ.	Баянхонгор аймгийн Номгон хайрхны өврийн шороон замын засварын ажлын гүйцэтгэгчээр "Их богд зам" ХХК шалгаран ажлыг гүйцэтгэн 2022 оны 08 дугаар сард ашиглалтад оруулснаар иргэдийн аюулгүй зорчих орчин нөхцөлийг хангасан.	100%
143		5.1.33. Төв гэрлэн дохиотой 4 замын уулзварын зүүн урд хэсгийн явган замын ажил	Хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	1. Мазаалай паркаас төв зам дагуу 627м2 талбайд Эко хавтанг суурилуулж шороон талбайд хучилт хийн явган зам барьсан. Мөн 508 дугаар байрны орчинд 225 м2 явган хүний зам тавьж хотын өнгө үзэмжийг сайжруулсан.	100%
144		5.1.34. Хуучнаар 12 дугаар байрны баруун талын хэсгийн явган зам	Хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Баянхонгор сумын хуучнаар 12 дугаар байрны баруун талд явган замыг 20 сая төгрөгийн санхүүжилттэй хийж ашиглалтад оруулж хотын өнгө үзэмжийг сайжруулсан.	100%
145		5.1.35. Хот доторх эвдэрсэн хүүхдийн тоглоом болон төв зам дагуух цэцгийн мандлыг засварлах	Хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Төв зам дагуух цэцгийн мандлыг засварлаж, хүүхдийн тоглоомын 3 талбайн засварыг ажлыг хийж байнгын ашиглалтад оруулсан.	100%
146		5.1.36. Театрын зүүн урд буй "Баянхонгор сум 60" самбар, ОБГ-ын зүүн талын замын эсрэг талд буй	Хотын өнгө үзэмж, иргэдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.	Баянхонгор сумын Рашаант, Номгон багуудын нутаг дэвсгэрт орон нутгийн хөгжлийн сангийн 18.091.400.00 төгрөгөөр "Илч шим" ХХК нь 1.Театрын зүүн урьд байрлалтай "Баянхонгор -60 самбар нь хийгдсэнээс хойш засварт ороогүй эвдэрч сүйтгэгдсэн байсныг засаж, шилэн доторх мэдээллийг шинээр хийж гэрэлтүүлэгтэй	100%
1	2	3	4	5	6

		самбарыг янзлах		болгосон байна. 2. Онцгой байдлын газрын зүүн талын авто замын эсрэг талд буй “Гэрэлт мэдээллийн” самбар нь шил хагарсан, дагалдах самбаруудын өнгө үзэмж чанар байдал муудсан байсныг самбар, хөл карказыг будаж, хүрээг болон эвдрэлийг янзалж гэрэлтүүлгийн эх үүсвэр, гэрэлтүүлгийг хийж өнгө үзэмжийг сайжруулан мэдээллийг шинэчилсэн байна.	
147		5.1.37. Баянхонгор сумын 7 багийн тоглоомын талбайн суурийн ажил	Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин бүрдүүлэх тоглоомын талбай бий болсон байна.	Баянхонгор сумын 7 багийн тоглоомын талбайд цементээр бетон хучилт хийж тэгшлэх, өнгөлөх ажлыг 58.2 сая төгрөгөөр “БИ БИ ДИ ЭМ ЭМ” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан.	100%
148		5.1.38. 2021 онд гүйцэтгэсэн Орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын хөлс	Орон нутгийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн иргэдэд олгох урамшууллыг бүрэн олгосон байна.	2021 онд гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажлын хөлс болох 45.0 сая төгрөг бүрэн олгогдсон.	100%
149		5.1.39. Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх	Иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх таатай орчин нөхцөл бүрдсэн байна.	Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг "Нью бест хаус" ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 07 дугаар сард улсын комисс ажиллуулж байнгын ашиглалтад оруулж, хүүхэд багачуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин бүрдсэн.	100%
150		5.1.40. Хүүхэд залуучуудын спорт цогцолбор амралт зугаалгын бүсийн тохижилт	Оготнотой булгийг түшиглэн хүүхэд залуучуудад зориулсан спорт цогцолбор байгуулж, иргэдийн амрах, зугаалах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна. /Сагсан бөмбөг, волейбол, хүүхдийн тоглоомын талбай, дугуйн зам, авто зогсоол, ариун цэврийн байгууламж, гэрэлтүүлэг, явган зам,	Оготнотой булгийн спорт цогцолбор болон амралт зугаалгын бүсэд Сагсан бөмбөг, Волейбол, Хүүхдийн тоглоомын талбай, Гэрэлт гудамж, ариун цэврийн байгууламж, Крикетийн талбай, түүнийг тойрсон дугуйн зам, амралт зугаалгын задгай талбай, явган хүний зам, 55 машины авто зогсоол зэргийг шинээр хийж гүйцэтгэн иргэдийн амрах, зугаалах таатай орчныг бүрдүүлсэн.	100%
1	2	3	4	5	6

			хүүхдийн парк, мөсөн талбай/		
151		5.1.41. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.	Ногоон байгууламжийг хэмжээг нэмэгдүүлж, түүнд шаардлагатай 3-аас доошгүй худаг гаргасан байна.	Баянхонгор сумын Эрдэнэмандал хайрхны өвөрт 2.6 га талбайд 10 төрлийн 1535 ширхэг модыг тарьж, амьдралтын хувь 85 хувьтай ургасан. Мөн төвийн бүсийг тарьц суулгацаар хангах зорилгоор шинээр байгуулагдаж буй Шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газарт 32 төрлийн багаж, тоног төхөөрөмж, 3 төрлийн 40.000 ширхэг харандаа суулгац, 3 төрлийн 17 кг модны үр, 2 төрлийн 19450 ширхэг тарьц суулгацын дэмжлэг үзүүлсэн. Мөн Түйн гол дагуух ойн зурвас болон Шинэ суурьшлын бүсийн хамгаалалтын ойн зурвасын усалгаанд шаардлагатай 3 ширхэг гүний худгийг гаргаад байна.	100%
152		5.1.42. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажил	Шинэ суурьшлын бүсийн дэд бүтэц сайжирч иргэдийг ая тухтай амьдрах орчин бүрдэх эхлэлийг тавина.	Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд Баянхонгор-Эрчим Хүч ЦТ ХХК нь 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 1. 0.4 кВ-ын шугам сүлжээний өргөтгөлийн ажил: Шинэ суурьшлын бүсийн гудамж хорооллын 0,4 кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажлыг УКШ-9 маркийн төмөр бетон тулгууртай нийт 1450м СИП-3*25 маркийн шугам сүлжээг угсарч хүчдэлд холбосон. Шинэ бүсэд амьдарч байгаа хэрэглэгчдийн хүсэлтээр 24 ш буулт хайрцаг шинээр угсарч холболт хийсэн. Шинэ суурьшлын бүсийн төвийн хэсэгт ашиглалтад шинээр орсон сургууль болон уурын зуух, барилга байгууламжийн гадна цахилгаан хангамжид 10 кВ-ын 1.2 км агаарын шугам болон 10/0.4 кВ-ын 250 кВА чадалтай КТП дэд станц 2ш шинээр угсарч ашиглалтад оруулсан байна. "Чандмань Баянхонгор" ХК Шинэ суурьшлын бүсэд 9 км цэвэр усны шугам, 500м3 багтаамжтай нөөцийн усан сангийн ажил, даралт өргөх насос станцын барилгын ажил зэргийг гүйцэтгэж, мөн 125м3/хон-ийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, 700м бохир ус татан зайлуулах шугам сүлжээг ашиглалтад оруулж, хэрэглэгчдийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах ажил хэвийн явагдаж байна. Энэхүү шугам сүлжээ ашиглалтад орсноор 640 хүүхдийн сургууль, 64 айлын орон сууцны барилга цэвэр усаар хангагдаж, бохир усны төвлөрсөн системд холбогдож байна.	100%
		5.1.43. Ашиглалтын хугацаа дууссан	Ашиглалтын хугацаа дууссан химийн бодисыг		
1	2	3	4	5	6

153		Химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулна	мэргэжлийн байгууллагаар устгуулсан байна.	Терроризмтой тэмцэх салбар зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/53 дугаар захирамжаар ажлын хэсэг гарч Боловсрол, шинжлэх ухааны газар, Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газарт хадгалагдаж байсан химийн бодисуудыг зохих журмын дагуу татан төвлөрүүлж химийн бодис хадгалах, устгах тусгай зөвшөөрөлтэй "Түмэн эгшиг" ХХК-д 2022 оны 06 сарын 4-ний өдөр хүлээлгэн өгсөн. Үүнд: Бага аюултай-16, дунд зэргийн аюултай-17, их аюултай-44, онц их аюултай-26, хаяг шошго байхгүй аюулын зэрэг нь тодорхойгүй 102, нийт 205 төрлийн 206.7 кг хуурай бодис, 436.6 литр шингэн бодис байсан. Ингэснээр бодисууд урвалд орох, орчныг бохирдуулж суралцагч, ажилтан, албан хаагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлсэн.	100%
154		5.1.44. Баянхонгор тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГазрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Явган замын хавтангийн үйлдвэрийн үйл ажиллагааг сайжруулсан байна.	Явган замын хавтангийн үйлдвэрт шаардлагатай явган замын болон блокны хэв, бусад бараа материалыг худалдаж авч, үйл ажиллагааг сайжруулсан. Энэ онд 18446 ширхэг эко хавтан, 9786 ширхэг явган замын хашлага үйлдвэрлэн Баянхонгор хотын тоосжилтыг бууруулж ажилласан.	100%
155		5.1.45. Аймгийн төвийн гэрэлтүүлгийн тээвэрлэлт, угсралтын ажил	Гэрэлтүүлгийг суурилуулсан байна.	Баянхонгор аймгийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2021 онд худалдан авсан Төв зам дагуу 90 ш баганатай гэрэл, Хөх толгойн зам дагуу 66 ш баганатай гэрэл, Төв замын уулзваруудад 4 ш 12 метрийн өндөртэй гоёлын гэрлийг тус тус угсарч туузан гэрлүүдийн холболт хийгдсэн. Мөн нийтийн эзэмшлийн гудамж хороолол болон төв зам, талбайн, гэрэлтүүлгийн засварт 300 ш гэрэлтүүлгийн толгой, 2,7,9 дүгээр багийн гудамжинд 248 ш баганатай гэрэл шинээр тоноглож засвар үйлчилгээг бүрэн хийж дуусгасан.	100%
156		5.1.46. Уурын зууханд усан шүүлтүүр хийх	Баянхонгор сумын 1 уурын зууханд усан шүүлтүүр суурилуулсан байна.	2021 онд Баянхонгор сумын 3 уурын зуухны 6 аманд, 2022 онд 1 уурын зууханд шүүлтүүр суурилуулсан.	100%
157		5.1.47. Улсын чанартай спорт тэмцээнд дэмжлэг үзүүлэх	3-аас доошгүй улсын чанартай спортын тэмцээнд дэмжлэг	Үндэсний бөх, футзаалны 21 аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Бадминтон, Крикетын Улсын аварга, Ламын гэгээний Их тойром үндэсний шагайн харваа, Бодибилдинг, Монголын мастеруудын	100%
1	2	3	4	5	6

			үзүүлсэн байна.	биеийн тамир спортын VI наадам зэрэг 7 арга хэмжээг зохион байгуулсан. Дээрх улсын чанартай тэмцээн уралдаан зохион байгуулагдсанаар орон нутгийн тамирчдын ур чадвар сайжирсан.	
158		5.1.48. Стандарт хэмжил зүйн хэлтсийн гадна засвар	Стандарт хэмжил зүйн хэлтсийн гадна засварын ажлыг хийж дуусгасан байна.	Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын хөөсөн дулаалга, гадна фасадын засварын ажлыг "Алтай гурван нуур" ХХК 2022 оны 08 дугаар сард хийж гүйцэтгэсэн. Тус засварын ажлыг хийж гүйцэтгэснээр барилгын дулаан алдалт багасаж ажилчдын ажиллах ая тухтай орчин бүрдсэн.	100%
159		5.1.49. Дөвөнтийн заалны гадна засвар	Дөвөнтийн заалны гадна засварын ажлыг хийж дуусгасан байна.	Дөвөнтийн спорт заалны гадна фасадын засварын ажлыг "Буян арвижих од" ХХК хийж гүйцэтгэн 2022 оны 09 дүгээр сард байнгын ашиглалтад оруулсан. Иргэд хүүхэд багачуудын спортоор хичээллэх орчин нэмэгдсэн.	100%
160		5.1.50. Аймгийн Засаг даргын Тамгын газар тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	Цахим сургалт, хурал уулзалтад шаардагдах ухаалаг дэлгэцтэй болно.	Засгийн газрын цахим уулзалтыг зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмжийг ухаалаг дэлгэцтэй болсноор ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгавар, Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн шуурхай хэлэлцүүлэгт тухай бүр оролцож байна.	100%
161		5.1.51. Баянхонгор сумын төв цэнгэлдэх хүрээлэнг тохижуулах	Ханын зураг зурж, зүлэгжүүлсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн технологийн багш нартай хамтран хандивын 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төв цэнгэлдэх хүрээлэнгийн индэр, баруун хананд Баянхонгор аймгийн байгалийн үзэсгэлэнт газрын зургийг зурж, Биеийн тамир спортын газар хандивын 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төв цэнгэлдэх хүрээлэнг зүлэгжүүлсэн.	100%
162		5.1.52. Баянхонгор сумын Угалз 4-р багийн айл өрхөд дулааны шугам татах ажил	Баянхонгор сумын 4-р багийн дэд бүтэц сайжирч иргэдийг ая тухтай амьдрах орчин бүрдэх эхлэлийг тавина.	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр багийн 6, 7 дугаар гудамжны дундуур дулаан, цэвэр усны 1 км шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулж 35 айлыг төвлөрсөн шугамд холбосон. Дээрх айлуудын шугам сүлжээнд холбох газар шорооны ажлыг "Мадока" ХХК 19.5 сая төгрөгөөр бүрэн хийж гүйцэтгэсэн. Дээрх айл өрхүүд төвлөрсөн дулааны шугамд холбогдсоноор ая тухтай амьдарч, ажиллах нөхцөл бүрдсэн.	100%
163		5.1.53. Шинэ хогийн цэг хүртэлх сайжруулсан шороон зам	Шинэ хогийн цэг хүртэл сайжруулсан шороон замтай болсон байна.	Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн 200.0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянхонгор сумын төвлөрсөн шинэ хогийн цэгийг байгуулсан. Тус хогийн цэг нь Өлзийт сумын 1 дүгээр багийн нутагт орших ба Баянхонгор - Говь-Алтай чиглэлийн улсын чанартай авто	100%
1	2	3	4	5	6

[illegible]

166		5.1.56. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд дэмжлэг үзүүлэх		Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Мэргэжлийн холбоод, Иргэний нийгмийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, идэвхжүүлэх, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоог урамшуулах ажлыг зохион байгуулсан. Хүүхэд залуучуудын оролцоог дэмжих зорилгоор Карл Попперийн мэтгэлцээний сургалт, "Нэг хүүхэд, нэг нүүдэл" төслийг амжилттай хэрэгжүүллээ.	100%
ЗУРГАА. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ					
167		6.1.1. Архивын байрыг иж бүрэн камержуулах	Архивын баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдал хангагдана.	Төрийн архивын сан хөмрөгийн баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангахаар “Айети юнипикэшн” ХХК-тай шууд гэрээ байгуулан нэмэлтээр 17 сая төгрөгийн үнэ бүхий 53 ширхэг камерыг сан хөмрөгт тавьж хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг ханган хяналт тавин ажиллаж байна.	100%
168		6.1.2. Иргэдийн хаягийн шинэчлэлийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шинэчлэх	Төрийн үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн байна.	Улсын бүртгэлийн хэлтсээс нийт 6622 хаягийг мэдээллийн санд өөрчлөлт хийлгэх дүгнэлт гарган иргэний улсын бүртгэл мэдээллийн санд хаяг шинэчлэгдсэнээр нийт өөрчлөх шаардлагатай хаягийн 91.06 хувь хөрвөж орсон.	90%
169	6.1. Аюулгүй нийгэм, амар тайлан орчин	6.1.3. Жаргалант, Богд сумдын цагдаагийн тасгийг шинэ байртай болох	Цагдаагийн тасгийн алба хаагчдын ажиллах, амьдрах ая тухтай орчин нөхцөл бүрдсэн байна.	Улсын төсвийн 2022-2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Богд, Жаргалант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн барилгын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ЦЕГ/202212010/ дугаартай тендерт оролцогч "Хорол Багана констракшн" ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгогдсоны дагуу гэрээ байгуулж, барилгын ажлыг 6 дугаар сарын 04-ны өдөр эхлэн Богд сумын тасгийн барилгын ажил 51 хувийн, Жаргалант сумын тасгийн барилгын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй байна. Цаг агаарын нөхцөл байдал, бараа материалын үнийн өсөлт тодорхойгүй байгаа, нийлүүлэлт бага байгаа зэргээс шалтгаалан барилга угсралтын ажлыг гүйцэтгэх боломжгүй байгаа талаар албан бичиг ирүүлсний дагуу ЦЕГ-ын СААА-нд албан бичгээр мэдэгдсэн.	70%
170		6.1.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогч нарын ар	Хоригдогч гэрийнхэнтэйгээ уулзах нөхцөл бололцоогоор хангагдсан байна.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198-р зүйлийн 3 дахь заалтыг хангах, хүний эрхийг хангах чиглэлээр хоригдлын удаан хугацааны эргэлт уулзалтын байрны засвар үйлчилгээг “Баян тал” ХХК-р захиалан хийлгэж шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хүлээлгэн өгсөн. Тус байр амралтын өрөө, гал тогоо, хүүхдийн өрөө	100%

		гэрийнхэнтэйгээ уулзах өрөөг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулж, орчин нөхцөлийг сайжруулах		гэсэн 3 тусдаа өрөөтэй ба удаан хугацааны эргэлтээр ирсэн ар гэрийнхэн ая тухтай байлгах хүүхэд тоглох, хоол үйлдвэрлэлийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Хоригдлын удаан хугацааны эргэлт уулзалтын байранд засвар үйлчилгээ хийснээс хойш 12 удаагийн эргэлт уулзалтыг тав тухтай орчинд зохион байгуулан ажиллаж байна.	
171		6.1.5. Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлыг зохион байгуулах, салбар зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, дэмжлэг үзүүлэх	Зөвлөлийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Хил хамгаалах туслах хүчний салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөг Аймгийн Засаг даргын А/24 дүгээр захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна 2022 оны байдлаар төлөвлөсөн ажлууд 100 хувь хэрэгжсэн байна.	100%
172		6.1.6. Хилийн 0203 дугаар салбар (Хатансуудал)-ын цэргийн байранд халаалтын нэгдсэн шугам, хилийн 0112 дугаар салбар /Цагаанбогд/-ын албаны байруудад засвар хийх ажилд дэмжлэг үзүүлэх	Цэргийн алба хаагчдын ажиллах, амьдрах нөхцөл зохих түвшинд сайжирсан байна.	Хилийн 0203 дугаар салбар (Хатансуудал)-ын цэргийн байранд халаалтын нэгдсэн шугам, хилийн 0112 дугаар салбар /Цагаанбогд/-ын албаны байруудад засвар хийх ажилд шаардагдах санхүүжилтийн асуудлыг бүрэн шийдвэрлэж засварын ажил бүрэн хийгдсэн болно.	100%
173		6.1.7. Баянхонгор сумын 2, 3, 7 багийн гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	Багийн иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдсэн байна.	Баянхонгор сумын 2, 3, 7 дугаар багийн гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлын тендер зарлан эрхийг Баянхонгор сумын ЗДТГ - т эрх шилжүүлсэн. Тус ажлын гүйцэтгэгчээр "Алтан завьяа ундарга" ХХК гэрээ байгуулан ажлыг эхлүүлэн 2022 оны 12 дугаар сард ашиглалтад оруулсан.	100%
174		6.1.8. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр 21 дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, гарсан зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан. Мөн 20 сумын 50	100%

				албан хаагчийг шинжээчийн сургалтад хамруулан ажиллалаа.	
175		6.2.1. Баянхонгор аймгаас 2021 онд татагдсан хугацаат цэргийн алба хааж байгаа цэргийн алба хаагчдыг эргэх, Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги салбаруудын үйл ажиллагаатай танилцах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх	Баянхонгор аймгаас 2021 онд татагдсан хугацаат цэргийн алба хааж байгаа 300 цэргийн алба хаагчдын алба хаах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Батлан хамгаалахын сайд Баянхонгор аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний хүрээнд иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах зорилгоор ажлын хэсэг томилон хонгор нутгийн цэрэг дайчдаа эргэх арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын орлогч Б.Батсууриар ахлуулсан, Цэргийн штабын дарга, хурандаа Г.Нэмэхбаяр болон бусад алба хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 02 дугаар сарын 23-аас 03 дугаар сарын 07-ны хугацаанд Улаанбаатар хот дахь Зэвсэгт хүчний 032, 326 дугаар анги болон Өвөрхангай аймаг дахь Зэвсэгт хүчний 256 дугаар анги, Өмнөговь аймаг Хилийн 0166 дугаар анги, Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид албаа хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчдаа эргэж хамтран дэмжиж ажилласан.	100%
176	6.2. Батлан хамгаалах салбар	6.2.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит Батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагдах спортын болон марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	Батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын нэрэмжит Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн буудлагын талбайн районд “Марш тактикийн аварга тасаг” шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулж явуулсан. Марш тактик тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах тэмцээнд 8 багийн 95 тамирчид оролцож эрэгтэй тасгийн “Тэргүүн” байрт Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 103 дугаар тусгай салбар, “Дэд” байрт Онцгой байдлын газар, “Гутгаар” байрт Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, эмэгтэй тасгийн “Тэргүүн” байрт Зэвсэгт хүчний 339 дүгээр анги, “Дэд” байрт Онцгой байдлын газар тус тус шагнагдсан.	100%
177		6.2.3. Цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн сургалтыг зохион байгуулах "Цэргийн алба зохион байгуулах заавар"-т нийцсэн хөдөлгөөнт сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх	Цэргийн алба зохион байгуулах зааварт нийцсэн хөдөлгөөнт сургалтын баазтай болсон байна.	Цэргийн штабаас сургалтын материаллаг бааз бүрдүүлэх зорилгоор аймгийн 2022 оны төсөвт суулгуулан аймгийн Засаг даргын захирамжаар 20 тонны контейнер худалдан авч Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн байрлалд тавьсан. Мөн зөөврийн сургалтын 40 ширээ, 40 сандал, хээрийн эвхдэг ор зэргийг тус тус бүрдүүлж сургалтад ашиглаж байна.	100%

178		6.2.4. Улс, аймаг Засаг даргын нэрэмжит, аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээн зохион байгуулах	Ерөнхий боловсролын сургуулийн 600 сурагчдад сэтгэл зүйн болон бие бялдрын өв тэгш хүмүүжил олгосон байна.	Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ой, энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан Баянхонгор аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээ, Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны А/365 дугаар захирамжийн дагуу ерөнхий боловсролын сурагчид, иргэд олон нийтэд Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, цэрэг-эх оронч хүмүүжил олгох, Монгол цэргээрээ бахархах үзлийг төлөвшүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн өв тэгш хүмүүжил олгох зорилгоор Зэвсэгт хүчний 339 дүгээр ангитай хамтран аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулсан. Цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн 4 тасаг, алслагдсан болон ойрын сумдын 9 тасаг нийт 13 тасаг оролцож хурд, хүч авьяас чадвараараа өрсөлдсөнөөс нэгдсэн дүнгээр тэргүүн байранд Б.Отгонпүрэв ахлагчтай Жаргалант сумын “Бид чадна” тасаг шалгарч шилжин явах цом, медаль, мөнгөн шагнал, дэд байранд Бууцагаан сумын У.Төгстөгөлдөр ахлагчтай “Буянт” тасаг шалгарч медаль, мөнгөн шагнал, гутгаар байранд Номундалай цогцолборын Г.Мөнхтогтох ахлагчтай “Шонхор” тасгийн хамт олон шалгарч медаль, мөнгөн шагнал, тусгай байранд Баянлиг сумын Б.Угтахбаяр ахлагчтай “Хатансуудал” баг, Галуут сумын Д.Алтаншагай ахлагчтай “Дайчид” баг тамирчид тус тус шалгарч аймгийн Засаг даргын “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнагдсан.	90%
179		6.2.5. Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн цэргийн гал тогооны барилга шинээр барих	Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдал хангагдсан байна.	Ангийн гал тогооны барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй, зоорийн давхар, 1 давхрын барилга бүрэн дууссан. Гал тогооны дотор засал хийгдэж байна.	90%
ДОЛОО. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО					
180	7.1. Ухаалаг засаглал	7.1.1. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн”, команд штаб, Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэг зохион байгуулах	Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” команд штабын сургууль хийгдсэн байна	Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургуулийг Өлзийт сумд 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 25-ны өдрүүдэд, Баянлиг сумд 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 09-ний өдрүүдэд, Команд штаб”-ын сургуулийг Галуут сумд 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 30-ны өдрүүдэд, Баацагаан сумд 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдрөөс 15-ны өдрүүдэд астрономийн 72, оперативын 2100 цагийн	100%

				багтаамжтай, 4 үе шаттайгаар тус тус зохион байгуулж, дээрх 6 сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн нийт 1283 ажилтан, албан хаагч, иргэд оролцож гамшгаас хамгаалах, хор уршгийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг ойлголтоо дээшлүүлсэн. Сургууль, дадлагыг танхимаар болон эрэн хайх, аврах ажиллагаа, хээрийн хүн, мал эмнэлэг дэлгэх дуурайлган үзүүлэх дадлага сургууль зэрэг үе шаттайгаар зохион байгуулсан нь сумдын Онцгой комисс, гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, иргэдэд үүсэж болзошгүй аливаа нөхцөл байдлыг бодитоор туршин харуулснаараа онцлог байсан болно. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургуулийг Өлзийт сум 93,2 хувь, “А”, Баянлиг сум 85,6 хувь, “В” үнэлгээтэй, “Команд штаб”-ын сургуулийг Галуут сум 81.2 хувь, “В”, Баацагаан сум 85.6 хувь, “В” үнэлгээтэй тус тус зохион байгуулж сумдын гамшгийн үеийн бэлтгэл бэлэн байдал хангагдсан.	
181	7.1.2. Төрийн албаны тухай хэрэгжилтийг хангаж, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Төрийн албаны шалгалтад шаардагдах тоног төхөөрөмжүүд шинэчлэгдсэн байна.	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр захирамжаар "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжлэг үзүүлэх, төрийн албаны шалгалт авахад техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 23.0 сая, шалгалт авах 20 ширхэг нөүтбүүкний зардал 42.0 сая, нийт 65.0 сая төгрөгийг зарцуулсан. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг төрийн албаны ерөнхий нөөц бүрдүүлэх шалгалтыг 2022 онд 2 удаа зохион байгуулж, 96 иргэний ерөнхий нөөцийг бүрдүүлсэн. Мөн төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх болон удирдах ажилтны 23 удаагийн тусгай шалгалтыг нийтэд зарлан 470 сул орон тооны 154 сул орон тоог нөхөж ажилласан байна.	100%	
182	7.1.3. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийлгэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Хэрэглэгчийн үнэлгээг өмнө оноос 5-с доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/230 дугаар захирамжаар үнэлгээ хийх захирамж гаргасан. Төрийн байгууллагын иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж гаргадаг өргөдөл гомдол санал хүсэлтийг хүлээн авах цахим систем, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээ авах цахим систем зэргийг https://bayanhongor.gov.mn/ албан ёсны цахим сайтад байршуулсан. Энэ системийг	70%	

				нэвтрүүлснээр төрийн байгууллагуудын цаасан суурьтай ажиллагааг багасаж, иргэдэд хүрэх төрийн байгууллагын үйлчилгээ ил тод нээлттэй болсон.	
183	7.1.4. “Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанар” судалгаа хийх	Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, халамж, даатгал, нийгмийн бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний чанарыг тодорхойлж, зөрчил дутагдлыг арилгана.	Судалгааны удирдамж боловсруулж Гэр бүлийн боловсролын судалгаа мэдээллийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Салбарын судалгаануудыг холбогдох мэргэжилтнүүд сар, улирал тутам хийж зөрчил дутагдлыг арилган агентлагуудыг удирдлага арга зүйгээр ханган ажилласан.	70%	
184	7.1.5. E-Mongolia системийн ашиглалтыг сайжруулах, иргэдэд таниулах, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах	Лавлагаа, мэдээлэл 520 төрлөөр нэмэгдэж иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг ойртуулна.	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөс сумдын төвүүдэд e-mongolia, операторын үйлчилгээг мэргэжил, арга зүйгээр ханган төрийн үйлчилгээг авах, цахим үйлчилгээг ашиглах талаар сургалт мэдээлэл сурталчилгааны ажлыг 20 сумын 2947 иргэнийг хамруулан зохион байгуулж иргэдийг цахим ур чадварт сургасан. Тайлант онд 93 төрлийн үйлчилгээ нэмэгдэн нийт 318 төрлийн үйлчилгээг 11167 иргэнд цахимаар үзүүлсний 4367 операторын, 6800 иргэний өөрийн эрхээр үзүүлсэн үйлчилгээ байна. Төрийн цахим үйлчилгээ авсан иргэний тоо өмнөх оноос 34 хувиар өссөн.	100%	
185	7.1.6. “Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. Үндсэн сайтын нэмэлт хөгжүүлэлт 2. Сумдын сайтын нэмэлт хөгжүүлэлт	Аймгийн хэмжээний 1, сумдын 20 цахим хуудасны үйл ажиллагаа сайжирч, мэдээллийн ил тод байдал нэмэгдэнэ.	Аймгийн хэмжээнд 10 агентлаг, 13 сум албан ёсны цахим веб сайтыг ашиглаж, аймгийн албан ёсны http://bayanhongor.gov.mn/ цахим сайтад холбогдож, сум орон нутаг, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, иргэд олон нийтийг мэдээллээр ханган мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. "Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг "Анар системс" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2022/158 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2022 оны 11 дүгээр 28-ны өдөр бүрэн хүлээлгэн өгсөн. Аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байгаа ДАШБОАРД буюу "аймгийн тоон мэдээллийн нэгдсэн систем"-ийг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж дууссан боловч батлагдсан төсөв хүрэлцэхгүй учраас хэрэгжээгүй.	70%	
186	7.1.6. “Баянхонгор аймгийн цахим	Аймгийн хэмжээний 192 төрлийн үндсэн тоон	"Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг "Анар системс" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн	50%	

	мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. Дашбоард хөгжүүлэлт /Тоон мэдээллийн цахим хяналтын самбар/ 2. Иргэдийн санал гомдол илгээх систем	мэдээллийг иргэд, байгууллагууд авч, санал, гомдол илгээх шууд систем бий болно.	2022/158 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2022 оны 11 дүгээр 28-ны өдөр бүрэн хүлээлгэн өгсөн. Аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байгаа ДАШБОАРД буюу "Аймгийн тоон мэдээллийн нэгдсэн систем"-ийг хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж дууссан боловч батлагдсан төсөв хүрэлцэхгүй учраас хэрэгжээгүй.	
187	7.1.6. "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлт хийх. Үүнд: 1. "Цахим Баянхонгор" Гар утасны АПП + хөгжүүлэлт 2. Цахим мэдээллийн тайлангийн систем хөгжүүлэлт	Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.	"Аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг 2022 оны жилийн хөгжийн төлөвлөгөөнд тусган ажлын даалгаврыг боловсруулж дууссан боловч батлагдсан төсөв хүрэлцэхгүй учраас хэрэгжээгүй.	30%
188	7.1.7. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан программ хангамж хөгжүүлэх	Аймгийн хэмжээний нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын жуулчид, олон нийтэд хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Баянхонгор хот болон бусад 19 сумын төвийн нутаг дэвсгэрт байрлах төрийн болон хувийн хэвшил, үйлчилгээний байгууллагын мэдээллийг агуулсан 360 дүрс бүхий орон зайн мэдээллийн системийн гар утасны хувилбарын хөгжүүлэлтийн ажлыг "Окурус" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд. Ажлын явц 70 хувьтай үргэлжилж байгаа үндсэн системийн хөгжүүлэлттэй уялдаж хийгдэх учраас удаашралтай байна.	70%
189	7.1.7. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360	Аймгийн хэмжээний нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын жуулчид, олон нийтэд	Баянхонгор сум болон бусад 19 сумын төвийн нутаг дэвсгэрт байрлах төрийн болон хувийн хэвшил, үйлчилгээний байгууллагын мэдээллийг агуулсан 360 дүрс бүхий орон зайн мэдээллийн системийн гар утасны хувилбарын хөгжүүлэлтийн ажлыг "Окурус" ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд. Ажлын явц 40 хувьтай үргэлжилж байгаа бөгөөд үндсэн системийн хөгжүүлэлттэй уялдаж хийгдэх учраас удаашралтай үргэлжилж байна.	50%

		технологид суурилсан гар утасны АПП (iOS, Android) хөгжүүлэх	хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.		
190		7.1.8. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, нэмэлтээр шаардлагатай системийн хөгжүүлэлтийг хийх	Эрүүл мэндийн үйлчилгээ бүрэн цахимжсан байна.	Аймгийн нэгдсэн эмнэлгийн E-Health программ хангамжид цахим өвчний түүх модулийг 14 тасаг нэгж буюу 100 хувь нэвтрүүлсэн. Тухайн иргэн цаасан карт авч явах шаардлагагүй болж, эмчид үзүүлсэн тэмдэглэл, оношилгоо шинжилгээний хариу гэх мэт өвчний бүх түүх цахим хэлбэрээр хадгалагдаж байна. E-Health программ ашигладаг бүх шатлалын эмнэлгүүдэд тухайн иргэн үзүүлэхэд өвчний цахим түүхийг нэгдсэн баазаас харах боломжийг бүрдүүлсэн. "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд хэрэгжиж буй E-Health программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, 2022 оны байдлаар 12 модуль, 460 гаруй функцийг ашиглаж байна. Цахим бүртгэл, Амбулаторийн үзлэг, Лабораторийн шинжилгээ, Түргэн тусламж, Яаралтай тусламж, Дүрс оношилгоо, Цус цусан бүтээгдэхүүн захиалга, зарлага, Стационарын тусламж үйлчилгээ, Хэвтүүлэх захиалга, Цахим өвчний түүх, Эм эмнэлгийн туслах материал захиалга зарлага, Иргэний эрүүл мэндийн цахим дэвтэр зэрэг нийт 12 төрлийн үйлчилгээг цахимжуулсан. "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд хэрэгжиж буй e-Health программыг аймгийн Нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн программ хангамжийн бааз 12 модуль, 460 гаруй функцийг ашиглаж байна. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй түргэн шуурхай үзүүлэх цахим мэдээллийн горимыг бүрдүүлэн ажилладаг.	100%
191		7.1.9. Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск (өөртөө үйлчлэх) машины систем хөгжүүлэн нэвтрүүлж, төрийн байгууллагууд болон нийтийн үйлчилгээний	Аймгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээг 1 төхөөрөмжөөс авах боломжийг аймгийн төвийн 4 цэгт, 2 сумын төвд бий болгоно	Төрийн үйлчилгээний өөртөө үйлчлэх 8 ширхэг КИОСК машины техникийн нөхцөл, программын даалгаврыг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон ажлыг 2 удаа зохион байгуулсан боловч аж ахуйн нэгж оролцоогүй. Үнэлгээний хороо шууд гэрээ байгуулах зөвлөмж өгсөн хэдий ч "Төрийн хэмнэлтийн хууль"-ийн дагуу санхүүжилт хийгдэх боломжгүй болсон. https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1653353842190 https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1650731933543	50%

		газруудад байршуулна			
192		7.1.10. Төрийн цахим шилжилтийн үр дүнг таниулах, тоон бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх “Inspire 2022” цахим шилжилтийг хүн бүрт” төслийг хэрэгжүүлэх	Иргэд ажил амьдралдаа технологийн дэвшлийг хэрэглэж хэвшүүлэх	Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 21-ний өдрийн А/272 дугаар захирамжийн дагуу "Дижитал Баянхонгор" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. "Дижитал Баянхонгор" арга хэмжээний хүрээнд "Цахим шилжилтийг хүн бүрд" уриатай "Inspire 2022" арга хэмжээг Импасофт ХХК, Имтатс ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 04 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд зохион байгууллаа. "Inspire 2022" арга хэмжээгээр 400 гаруй иргэд төрийн албан хаагч, 800 гаруй ЕБС-ын ахлах ангийн сурагчдад мэдээллийн технологийн чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулав. Мөн төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан 40 ажилтан мэргэжилтнүүдэд "Сүпер Админ" нэртэй Active director, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал сэдвийн хүрээнд 16 цагийн чадавхжуулах (24.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий) сургалтыг үнэ төлбөргүй зохион байгууллаа.	100%
193		7.1.11. Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж	Багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл сайжирч чадавхажсан байна.	Багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд 19 сумын 40 багийн Засаг дарга нарт 40 мотоцикл, Баянхонгор сумын 10 багийн Засаг дарга нарт 10 компьютерыг шийдвэрлэж ажилласан.	100%
194		7.1.12. Сумдын газрын даамлуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх	Мэргэжлийн шаардлага, стандартад нийцсэн хүчин чадалтай компьютер тоног төхөөрөмжөөр хангагдана.	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 16 сумдын газрын даамлуудад Dell -ийн i7-10-р үетэй процессор, 8GB шуурхай санах ойтой, 24 инчийн дэлгэцтэй 16 компьютер, 1 нөүтбүүкийг хүлээлгэн өгч сумдын Газрын даамлуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.	100%
195		7.1.13. Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэх	Дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг 80-аас дээш хувьд хүргэсэн байна.	Орон нутагт хэрэгжиж байгаа 16 дэд хөтөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэн ажилласан. Сан хөмрөгийн баримтыг иж бүрэн нягтлан шалгах хөтөлбөр 100 хувьтай, Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх” аймгийн хөтөлбөр, Цахим архив - Баянхонгор хөтөлбөр, "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр - III" аймгийн дэд хөтөлбөр, Хуримтлалтай Хонгорчууд аймгийн дэд хөтөлбөр батлах тухай, Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого, Торгон сүрэг хөтөлбөр, Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрүүд 90-с дээш	90%

			хувьтай, Эдийн засгийг сэргээн хөгжүүлж, тогтвортой хөгжлийг бий болгох “Баялаг бүтээгч-Баянхонгор” хөтөлбөр, "Зөв амьдрал" дэд хөтөлбөр, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөр, "Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт - 2028" дунд хугацааны бодлогын баримт бичиг, "Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах” хөтөлбөр, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого аймгийн дэд хөтөлбөрүүд 70-90 хүртэл хувьтай, Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр 60.67 хувьтай, "Ухаалаг Баянхонгор" хөтөлбөр 42.89 хувьтай, дунджаар 83.22 хувийн хэрэгжилттэй байна.	
196	7.1.14. www.bayankhongor.igovernment.mn хяналт шинжилгээ, үнэлгээний цахим санг нэвтрүүлнэ.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сантай болж хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн дээшилсэн байна.	Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний цахим системийг нэвтрүүлж, 61 нэгж, байгууллагаас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, Дэд хөтөлбөр, Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомж , тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрийн хэрэгжилт, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, Ил тод байдлын шалгуур үзүүлэлт зэрэг 14 төрлийн тайланг цахимаар авч, цахимаар үнэлгээ, зөвлөмж өгч ажилласан. Ингэснээр аймгийн Засаг даргын харьяа байгууллага, сумдын тайлангийн ирц сайжирч, 2022 оны жилийн эцсийн байдлаар 95 хувьд хүрч өмнөх оны цахим тайлагналаас 33.6 хувиар нэмэгдсэн байна.	100%
197	7.1.15. Баянхонгор аймаг дахь терроризмтай тэмцэх ажиллагааг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг	Төлөвлөгөөний биелэлтийг 85 хувьд хүргэнэ.	Баянхонгор аймаг дахь терроризмтай тэмцэх ажиллагааг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа. Монгол Улсын терроризмтай тэмцэх зөвлөлөөс мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтад 300 орчим төрийн албан хаагчийг хамруулан зохион байгуулж, 5.0 сая/төг-ийн үйл	100%

		үзүүлэх		ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан. - Аймгийн хэмжээнд хадгалагдаж байгаа хэрэглэгдэхүүнээс гарсан химийн бодисуудын тооллого, судалгааг хийж, аюулгүй цэгт түр төвлөрүүлэн нэгтгэж химийн бодисын устгал хийх эрх бүхий ААН-д хүлээлгэн өгсөн бөгөөд Баянхонгор аймаг дахь ээлжит хурлыг терроризмтай тэмцэх ажиллагааг зохицуулах салбар зөвлөлийн 3 удаа зохион байгуулсан. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сүм хийдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.	
198		7.1.16. Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх	Төлөвлөгөөний биелэлтийг 85 хувьд хүргэнэ.	Аймгийн Засаг даргын 2022 оны А/52 дугаар захирамжаар Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаанаас сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөний хүрээнд Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар хадгалагдаж байгаа хуурай 206.7 кг, шингэн 436.6 литр бодисыг устгал хийх компаниар устгуулан ажиллалаа. - Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалд томилогдох хүсэлт гаргасан 6 иргэнийг аюулгүй байдлын шалгалтад хамруулж, төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг сумдын ЗДТГ-т хэрэгжүүлэн ажиллав. - Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, аймгийн хэмжээний ундны усны аюулгүй байдлыг тодорхойлж нөхцөл байдлыг тодорхойлох ажлыг зохион байгуулав.	100%
199	7.1. Ухаалаг засаглал	7.1.17. Хурлын ажлын албаны ажиллах хэвийн үйл ажиллагааг хангаж, автомашиныг шинэчлэх	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах	Санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй учраас автомашин аваагүй.	0%

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

БАЯНХОНГОР АЙМГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Хэрэгжилт гаргах арга хэмжээний тоо			199
Үүнээс	Үр дүнтэй	100%	149
	Тодорхой үр дүнд хүрсэн	90%	18
		70%	16
	Эрчимжүүлэх шаардлагатай	50%	7
		30%	2
	Үр дүнгүй	0%	7
Хэрэгжилтийн дундаж			90.7%

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР